



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2024/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Аудитор:	Д.Дэмбэрэлсүрэн
		Цахим хаяг: demberelsurend@audit.gov.mn
	Аудитор:	Д.Дүүрэнжаргал
		Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СИТХ	Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/19

Сайншанд сум

Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт,  
тайланг баталгаажуулах тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.5 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.1 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан, дүгнэлтийг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн 115/А1071060 ДГА-2024/01/НА-СТА-ТЕЗ дугаар бүхий албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталгаажуулсугай.
3. Аудитын тайлан, албан шаардлагыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т даалгасугай.



Т.ГАН-ӨЛЗИЙ

010010023

This PC: D/2023 onii ajil/A4 toot

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын  
газрын дарга, тэргүүлэх аудиторын  
2024 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн  
А/19 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Аудитын санал дүгнэлт

4417144353  
ЕНУА0056 9025707

Д/д	Санхүүгийн тайлангийн нэр	Аудитын код	Санал дүгнэлт
1	Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагч	ДГА-2024/01/НА-СТА-ТЕЗ	Өөрчлөлтгүй

\*\*\*00\*\*\*

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын  
газрын дарга, тэргүүлэх аудиторын  
2024 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн  
А/19 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

4417144353  
EHOA0056 9025707

Д/д	Зөрчлийн утга	Дугаар	Хариуцах албан тушаалтны нэр
1	Зөрчил арилгах тухай	115/А1071060 ДГА-2024/01/НА-СТА	Аймгийн Засаг дарга О.Батжаргал, Аймгийн ерөнхий санхүүч Т.Анхчимэг

\*\*\*оОо\*\*\*



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: domogovi@audit.gov.mn

2024.04.19 № 1-6/343

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Дорноговь аймгийн аймгийн ТЕЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймгийн татварын болон татварын бус орлогыг 120,058.4 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэл 78.4 хувьтай буюу 94,161.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төсвийн орлого 25,897.2 сая төгрөгөөр дутуу биелсэн нь газрын дуудлага худалдааны орлого 31,051.7 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна. Энэ нь БХБС-ын 2023 оны 1/2878 тоот албан бичгээр газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд шинээр газар олгох үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотой газрын биржийн цахим системд хаалт хийж 3 сарын хугацаанд газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах боломжгүй болсон нь нөлөөлсөн байна.

### Аудитын гол асуудал

1. Тайлант онд аймгийн хэмжээнд 5 сумын нутгийн захиргааны байгууллага нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан нийт 205.2 сая төгрөгийг хүлээн авч, сургалтын төлбөрийн дэмжлэг, багш нарт дэмжлэг үзүүлэх, баяр наадам зохион байгуулах, үндсэн хөрөнгө бэлтгэх зэргээр зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9-т "Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж нь орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр байна" гэж заасантай нийцэхгүй байна.

010020100

2. Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Журам, гэрээний үлгэрчилсэн загвар шинэчлэн батлах тухай” журмын 3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсэгт “түрээслүүлэгч түрээсийн орлогын 50 хувийг байгууллагын нэмэлт орлогын дансанд, 50 хувийг ...” гэж заасан байна. Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-т “төсвийн орлого гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 47 дугаар зүйлийн 47.1.5-т “төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого”, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-т “төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого” гэж заасныг тус тус зөрчсөн нь төсвийн байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны орлого бүрэн төвлөрөхгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,438,091.3	57,521,654.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	21,259,063.9	16,052,195.0
33	АВЛАГА	4,662,075.9	6,530,407.2
34	УРЬДЧИЛГАА	5,324,688.9	11,007,022.6
35	БАРАА МАТЕРИАЛ	6,127,712.7	7,089,748.7
36	НӨӨЦИЙН БАРАА	64,549.9	359,821.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	16,482,459.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	121,089,781.3	130,948,636.9
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	8,306,414.4	11,627,500.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	112,783,366.9	119,321,135.9
39200	Биет хөрөнгө	106,206,216.8	112,039,002.0
39300	Биет бус хөрөнгө	6,577,150.1	7,282,133.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	158,527,872.5	188,470,291.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	33,060,786.3	63,167,382.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,540,420.2	33,535,466.7
41300	Өглөг	2,613,802.3	23,154,881.1
41400	Урьдчилж орсон орлого	5,926,617.9	10,380,585.6
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24,520,366.1	29,631,915.3
42200	Урт хугацаат зээл	24,520,366.1	29,631,915.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	125,467,086.3	125,302,909.7
51	Засгийн газрын хувь оролцоо	125,467,086.3	125,302,909.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	19,295,398.0	19,297,398.0
51200	Хуримтлагдсан үр дүн	65,925,232.4	65,286,670.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	158,527,872.5	188,470,291.7

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	130,941,647.0	194,021,914.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	74,194,213.8	89,586,635.6
110	Орлогын албан татвар	35,077,820.3	62,372,714.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	23,844,995.0	35,658,525.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-804,856.3	-905,158.5
1103	ААН-ын орлогын албан татвар	12,037,681.6	27,619,348.2
113	Хөрөнгийн албан татвар	3,518,187.4	3,838,773.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	35,598,206.0	23,375,147.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,295,069.1	65,892,373.5
120	Нийтлэг татварын бус орлого	15,915,315.7	40,195,333.1
121	Хөрөнгийн орлого	57,475.0	25,650.0
122	Тусламжийн орлого	0.00	100,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	17,322,278.4	25,571,390.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,452,364.1	38,542,904.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	101,858,627.3	172,795,648.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	101,858,627.3	172,795,648.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,394,197.2	158,347,392.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,060,898.5	16,831,258.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,610,156.4	2,078,333.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,510,123.5	1,211,593.8
2104	Хангамж, бараа материалын зардал	44,588,443.9	98,133,103.1
2105	Нормативт зардал	1,581,868.8	461,921.7

441714453  
ЕЮА0056 9025707

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,153,871.3	681,520.4
2107	Томилолт, зочны зардал	1,374,011.6	272,158.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,894,419.1	19,350,264.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,620,404.1	19,327,238.9
211	ХҮҮ	946,300.0	300,000.0
212	ТАТААС	50,000.0	294,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,468,130.2	13,854,256.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	29,083,019.6	21,226,265.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	7,490.7	2,387.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	122,875,837.9	23,984,443.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-93,785,327.6	-2,755,791.0

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	79,650,551.9	42,522,321.1	99,147,124.2	221,319,997.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	36,991,764.8	25,454,149.4	60,369,322.3	-2,076,591.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	42,658,787.2	17,068,171.8	159,516,446.5	219,243,405.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	-20,905.8	0.0	-20,905.8
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-4,441.1	0.0	35,355.4	30,914.3
7	Өмчид гарсан өөрчлөлт	-159,758.0	0.0	158,758.0	-1,000.0
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-93,785,327.6	-93,785,327.6
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	42,494,588.0	17,047,265.9	65,925,232.4	125,467,086.3
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	42,494,588.0	17,047,265.9	65,925,232.4	125,467,086.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,313,537.7	-168,770.7	2,359,387.1	-122,921.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	40,181,050.3	16,878,495.3	68,284,619.5	125,344,165.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	2,000.0	168,687.1	-242,157.7	-71,470.6
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,313,537.7	0.0	0.0	2,313,537.7
17	Өмчид гарсан өөрчлөлт	472,468.6	0.0	0.0	472,468.6
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-2,755,791.0	-2,755,791.0
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	42,969,056.6	17,047,182.3	65,286,670.8	125,302,909.7

4417144353  
EЮА0056 9025707

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	146,822,565.9 5	190,685,574.94
11	ТАТВАРЫН ОРЛОГО	74,194,213.78	86,950,435.13
110	Орлогын албан татвар	35,077,820.34	59,736,514.34
1100	Хувь хүний орлогын албан татвар	23,844,995.05	35,658,525.07
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-804,856.32	-905,158.47
1103	ААН-ын орлогын албан татвар	12,037,681.61	24,983,147.74
113	Хөрөнгийн албан татвар	3,518,187.42	3,838,773.74
118	Бусад татвар, төлбөр, хураамж	35,598,206.02	23,375,147.06
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,389,314.78	10,240,444.67
1181	Газрын төлбөр	29,863,489.36	11,413,373.73
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,345,401.89	1,721,328.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,315,555.58	64,197,525.75
120	Нийтлэг татварын бус орлого	29,935,802.23	38,600,485.29
121	Хөрөнгийн орлого	57,475.00	25,650.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	17,322,278.36	25,571,390.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,312,796.59	39,537,614.05
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	12,132,155.70	33,542,719.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,139,873.14	3,315,441.77
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	98,166.05	120,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,942,601.70	2,559,452.68
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	88,047,389.74	126,940,044.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,047,389.74	126,940,044.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,294,128.89	80,082,419.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,304,336.05	22,290,657.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,842,846.28	3,547,504.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,909,270.20	3,035,506.75
2104	Хангамж, бараа материалын зардал	11,668,431.07	11,216,156.56
2105	Нормативт зардал	947,587.28	290,992.02
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,180,179.07	949,040.75
2107	Томилолт, зочны зардал	1,341,922.30	288,251.89
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,306,512.60	23,836,034.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,793,044.03	14,628,275.35
211	ХҮҮ	946,300.00	300,000.00
212	ТАТААС	50,000.00	294,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,756,960.85	46,263,624.96
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	58,775,176.21	63,745,530.27
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	3,064,577.46
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	45,593,232.67	72,866,987.73
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,593,232.67	72,866,987.73
2200	Дотоод эх үүсвэрээр	45,593,232.67	72,866,987.73
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	45,593,232.67	-69,802,410.27
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,009,073.04	850,011.08
14	Бусад эх үүсвэр	38,108.26	1,000,000.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,047,181.30	149,988.92
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	12,172,870.50	-5,206,868.91
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,086,193.40	21,259,063.90
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,259,063.90	16,052,194.99

4417144353  
ЕЮА0056 9025707

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	163,640,621.70	133,119,156.23	30,521,465.47	81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	109,078,433.70	92,649,655.66	16,428,778.04	85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,893,379.70	45,781,426.57	5,111,953.13	90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,600,020.70	15,687,545.67	912,475.03	95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,151,365.70	1,942,295.19	209,070.51	90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,334,781.10	9,439,063.23	895,717.87	91
2104	Хангамж, бараа материалын зардал	1,807,783.90	1,652,449.45	155,334.45	91
2105	Нормативт зардал	223,735.80	220,364.39	3,371.41	98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,044,699.20	1,882,083.70	162,615.50	92
2107	Томилолт, зочны зардал	302,527.00	256,644.49	45,882.51	85
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,867,885.50	11,957,012.30	1,910,873.20	86
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,560,580.80	2,743,968.15	816,612.65	77
211	ХҮҮ	1,735,711.50	300,000.00	1,435,711.50	17
212	ТАТААС	300,000.00	294,000.00	6,000.00	98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,149,342.50	46,274,229.09	9,875,113.41	82
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	54,325,947.80	45,040,924.75	9,285,023.05	83
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,823,394.70	1,233,304.33	590,090.37	68
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,562,188.00	40,469,500.57	14,092,687.43	74
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	163,640,621.70	125,518,995.35	38,121,626.35	77
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,870,282.40	25,571,390.46	1,298,891.94	95
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	119,755,488.00	97,416,074.81	22,339,413.19	81
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	17,014,851.30	2,531,530.08	14,483,321.22	15
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	12,246,370.95	-12,246,370.95	0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	4,646,210.08	-4,646,210.08	0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,940.00	1,824.00	116.00	94
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	104	104	0.00	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	918	860	58.00	94

431 144353  
ЕЦОАГ-56-0025707

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	10,039,100.88	(10,039,100.88)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	9,999,017.57	(9,999,017.57)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	8,757,485.62	(8,757,485.62)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	38,780.52	(38,780.52)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,000.00	(1,000.00)
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	4,144.55	(4,144.55)
2104	Хангамж, бараа материалын зардал	-	82,991.51	(82,991.51)
2105	Нормативт зардал	-	16,551.20	(16,551.20)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	82,624.60	(82,624.60)
2107	Томилолт, зочны зардал	-	24,316.00	(24,316.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	6,801,142.11	(6,801,142.11)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,705,935.13	(1,705,935.13)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,241,531.95	(1,241,531.95)
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	36,654.40	(36,654.40)
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,204,877.55	(1,204,877.55)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	40,083.31	(40,083.31)
2200	Дотоод эх үүсвэрээр	-	40,083.31	(40,083.31)
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	10,039,100.88	(10,039,100.88)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	10,039,100.88	(10,039,100.88)

4417144353  
EЮА0056 9025707

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дорноговь аймаг “Экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, иргэн бүр нь тогтвортой хөгжлийн боловсролтой, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай, амьжиргааны түвшин өндөр, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвараар тэргүүлэгч аймаг болно” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хангахад дараах стратегийн зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд,

- Байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглаж, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн, орчны бохирдол, доройтлыг бууруулна.
- Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурал, нийгмийн эмзэг байдлыг бууруулж, амьжиргааны түшинг дээшлүүлнэ.
- Иргэн бүрийн тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлж, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, хариуцлагатай уул уурхай, тогтвортой хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ.
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Хууль ёсыг эрхэмлэсэн, иргэдэд хүртээмжтэй, ил тод, хариуцлагатай, иргэдийн оролцоог бүх шатанд хангасан нэгдмэл бодлоготой сайн засаглалыг бэхжүүлнэ.

Тайлант 2023 оныг Засаг даргын А/01 дүгээр захирамжаар “Нээлттэй Дорноговь” зорилтот жил болгон зарласан байна. Уг зорилгын хүрээнд 5 зорилт 90 арга хэмжээг боловсруулсан ажиллаж хэрэгжилт 91 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- ✓ Аймгийн онцлог, түүх, соёл, өөрсдөд буй боломж, нутгийн брэндээ ард түмэнд таниулах, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх замаар аймаг орон нутгаа хөгжүүлэх;
- ✓ Иргэдэд ажиллаж амьдрах, аж ахуйн нэгж байгууллагад үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэх;
- ✓ Эдийн засаг, нийгмийн харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- ✓ Мэргэжлийн ажиллах хүчний хомсдолыг багасгах, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн тодорхой салбарын хөгжлийг эрчимжүүлэхэд хүний нөөцийг бэхжүүлэх, албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр сургалт явуулах зэргээр зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг дэмжих;

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь:

- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Аймгийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх, аймгийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, аймгийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан шийдвэрлүүлэх, энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан асуудлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох тооцоо,

үндэслэл бүхий саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэх;

- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Аймгийн хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авах чиг үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь төсвийн 30 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийснээс, төлөвлөгөөт хяналт шалгалтыг 26 байгууллага, төлөвлөгөөт бусаар 4 байгууллагад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Шалгалтаар 425.4 сая төгрөгийн зөрчил илэрч, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 124 акт тогтоон, 11 албан шаардлагыг хүргүүлсэн байна. Тайлант хугацаанд 283.3 сая төгрөгийн төгрөгийн төлбөрийг барагдуулж ажилласан ба биелэлт 66.6 хувьтай байна.

Монгол Улсын “Шилэн дансны тухай хууль”-д заасны дагуу 14 сумын 45 төсвийн байгууллага, аймгийн төвийн 10 байгууллага, нийт 55 байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн эсэхэд хяналт шалгалтыг хийж, нийт 8,008 мэдээллийг цахим хуудсанд тухай бүр байршуулж мэдээлэхээс 7,486 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 522 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорноговь аймгийн ТЕЗ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/646 дугаар аймгийн Засаг даргын захирамжаар батлуулсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт *ороогүй* байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,942.4 сая төгрөгөөр буюу 18.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	21,259.1	16,052.2	(5,206.9)
Авлага	4,662.1	6,530.4	1,868.3
Урьдчилгаа	5,324.7	11,007.0	5,682.3
Бараа материал	6,127.7	7,089.8	962.1
Нөөцийн бараа	64.5	359.8	295.3
Бусад эргэлтийн хөрөнгө	-	16,482.5	16,482.5
Урт хугацаат хөрөнгө оруулалт	8,306.4	11,627.5	3,321.1
Үндсэн хөрөнгө	112,783.4	119,321.1	6,537.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>158,527.9</b>	<b>188,470.3</b>	<b>29,942.4</b>
Өр төлбөр	33,060.8	63,167.4	30,106.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	125,467.1	125,302.9	(164.2)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>158,527.9</b>	<b>188,470.3</b>	<b>29,942.4</b>

*Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтүүдээс авлага данс, бараа материалын данс, нөөцийн барааны данс, бусад эргэлтийн хөрөнгийн данс, урт хугацаат хөрөнгө оруулалт данс, үндсэн хөрөнгийн данс, өр төлбөрийн данснууд нэмэгдэж, мөнгөн хөрөнгийн данс, засгийн газрын хувь оролцоо данснууд буурсан өөрчлөлт гарсан байна.

**3.4.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 16,052.2 сая төгрөг болж, өмнөх оноос 5,206.9 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	1.8	0.7	(1.1)
Банканд байгаа бэлэн мөнгө	21,257.3	16,051.5	(5,205.8)
<b>Төгрөг</b>	<b>21,257.3</b>	<b>16,051.5</b>	<b>(5,205.8)</b>
Төрийн сангийн харилцах	19,924.7	14,590.2	(5,334.5)
Арилжааны банк дахь харилцах	1,332.6	1,461.3	128.7
<b>Дүн</b>	<b>21,259.1</b>	<b>16,052.2</b>	<b>(5,206.9)</b>

*Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд: Аймаг болон сумдын орон нутгийн хөгжлийн санд 2,825.2 сая төгрөг, хоршоо хөгжүүлэх санд 1,267.7 сая төгрөг, нөхөн сэргээлтийн санд 561.9 сая төгрөг, байгууллагуудын ахмадын санд 162.1 сая төгрөг, нэмэлт дансны төвлөрүүлэлт 1,206.8 сая төгрөг, аймгийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд 8,586.5 сая төгрөгийн тус тус төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Арилжааны банканд нийт 14 байгууллагын 1,461.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн санд 1,442.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь "Түрээсийн орон сууц" багц-2 хөтөлбөрийн тендер зарлагдаж үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан урьдчилгааг олгож, гүйцэтгэл дуусаагүй тул үлдэгдэл олгогдоогүйгээс шалтгаалсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газар: Тайлант онд 3.8 сая төгрөгийн 3 гүйлгээг журамд заасан хэмжээнээс хэтрүүлсэн байна. Мөн 6.5 сая төгрөгийн 11 гүйлгээний бэлэн мөнгөний тайланг журамд заагдсан маягтын дагуу бэлтгээгүй зөрчилд зөвлөмжийг хүргүүлсэн.
- Сайхандулаан сумын Засаг дарга: Мал хамгаалах сангийн 0.3 сая төгрөгийн үлдэгдлийг нөхөн сэргээх сангийн тайлантай нэгтгэж тайлагнасан байна. Тус санг зарцуулах журам хүчингүй болсон тул сангийн үлдэгдэл хөрөнгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.
- Даланжаргалан Засаг даргын Тамгын газар: Тайлант онд шалгагдагч байгууллага нь түр дансаар дамжуулан нийт 5.7 сая төгрөгийн 3 гүйлгээг журамд заасан ЖМС-ийн хэмжээнээс хэтрүүлсэн зарцуулсанд журмыг баримтлан ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.
- Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газар: Тайлант онд 4 зарцуулалтын нийт 6.2 сая төгрөгийг журамд заасан жижиг мөнгөн сангийн хэмжээнээс хэтрүүлсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

#### **3.4.2 Авлага**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 6,530.4 сая төгрөг болж, өмнөх оноос 1,868.4 сая төгрөгөөр өссөн байна.

#### *Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	43.0	12.9	(30.1)
Төлбөртэй үйлчилгээний авлага	1.3	1.3	-
Зээлийн хүүгийн авлага	40.6	47.0	6.4
Дансны авлага /ТӨҮГ/	1,175.6	1,298.7	123.1
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	2.0	1.2	(0.8)
Байгууллагаас авах авлага	459.6	1,185.5	725.9
Хувь хүмүүсээс авах авлага	25.1	91.0	65.9
Зээлийн авлага	2,914.8	3,892.8	978.0
<b>Дүн</b>	<b>4,662.0</b>	<b>6,530.4</b>	<b>1,868.4</b>

*Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт авлагын 3,918.1 сая төгрөг нь сумдын ХХС-ийн, 61.8 сая төгрөг нь сумын болон аймгийн ОНХС-ийн, 84.6 сая төгрөг нь өрхийн эрүүл мэндийн төвүүдийн, 128.4 сая төгрөг нь Зам-Үүд сумын Орон нутгийн хөрөнгө оруулалтын, 890.4 сая төгрөг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын, 1,112.2 сая төгрөг нь Чандмань-Илч ОНӨ ХХК-ийн, 334.9 сая төгрөг нь бусад байгууллагын авлагын үлдэгдэл байна.

#### Аудитын илрүүлэлт

- Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газар: Тайлант онд нийт 3 албан хаагчид хоногийн зөрүү үүсгээнд тооцоог тайлант хугацаанд дуусгах зөвлөмжийг завсрын аудитаар хүргүүлсэн.
- Даланжаргалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Тайлант оны 11 дүгээр сарын нийт цалингийн 8.8 сая төгрөгийн зардлыг нийгмийн даатгалын тайланд 9.4 сая төгрөгөөр буюу 0.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн.
- Сайхандулаан сумын Хоршоог хөгжүүлэх сан: Зээлдэгчдийн төлсөн эргэн төлөлтийн орлогыг зээлийн авлага бууруулалгүй шууд орлогод бүртгэсэн. Мөн шинээр олгосон зээлийг санхүүгийн байдлын тайланд авлага үүсгэлгүй, шууд зардалд бүртгэсэн зэрэг алдааг залруулж, цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг баримталж ажиллах талаар зөвлөмжийг хүргүүлсэн.
- Сайншанд сумын Зүүнбаян багийн Тохижилтын алба: Өмнөх оны 781.0 мянган төгрөгийн он дамжсан авлагын үлдэгдлийг барагдуулаагүй зөрчилд албан шаардлагыг хүргүүлсэн.

Аудитын явцад залруулсан:

- Өргөн сумын Засаг даргын Тамгын газар: Тус байгууллага нь 3.5 сая төгрөгийн хувь хүмүүсээс авах байрны түрээсийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй алдааг аудитын явцад залруулсан.
- Өргөн сумын Хоршоог хөгжүүлэх сан: Санхүүгийн байдлын тайлангийн зээлийн авлагын эхний болон эцсийн үлдэгдэл, судалгааны дүнгээс нийт 56.1 сая төгрөгөөр зөрүүтэй, авлагын дүнг 2.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг аудитын явцад залруулсан.
- Замын-Үүд сумын Хоршоог хөгжүүлэх сан: Тайлант онд авлагын үлдэгдлийг зээлийн судалгааны дүнгээс 16.1 сая төгрөгөөр илүү, өмнөх үеийн үр дүнг 8.5 сая төгрөгөөр бууруулж, өр төлбөрийн эцсийн үлдэгдлийг 5.2 сая төгрөгөөр дутуу, тайлант оны үр дүнг 29.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан зэрэг 4 алдааг аудитын явцад залруулсан.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 11,007.0 сая төгрөг болж, өмнөх оноос 5,682.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл*

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	505.4	599.6	94.2
<b>Урьдчилгаа тооцоо</b>	<b>4,819.30</b>	<b>10,407.4</b>	<b>5,588.1</b>
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	4,811.60	10,400.5	5,588.9
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	6.9	6.9	-
Цалингийн урьдчилгаа	0.8	0	(0.8)
<b>Дүн</b>	<b>5,324.7</b>	<b>11,007.0</b>	<b>5,682.3</b>

*Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материал бэлтгэх урьдчилгаа дансны үлдэгдэл 10,400.5 сая төгрөг нь “Чандмань Илч” ОНӨ ХХК-ийн “Мандах наран-5”, “Саран хөхөө” театрын тендерийн ажилтай холбоотойгоор материалын захиалга, уурын зуухны тоног төхөөрөмж, барилгын материал худалдан авахтай холбоотой бараа материал бэлтгэсэн, урьдчилж гарсан зардлын дансны үлдэгдэлд байгаа 15.6 сая төгрөг нь 2019 онд “Турникет Монголиа” ХХК-аар Сайншанд болон Замын-Үүд сумын 2 дугаар сургуулиудад суурилуулах турникет системийн урьдчилгаа төлбөрийг аймгийн Засаг даргын хөтөлбөрийн зардал данснаас шилжүүлэн тухайн ажил нь хийгдээгүйн улмаас Цагдаагийн байгууллагад шилжсэн авлага, 40.0 сая төгрөг нь “Үүлэн зардас” ХХК-аар аймгийн түүхэн кино бүтээлгэхээр 2019 онд урьдчилж шилүүлсэн зардал, 300.0 сая төгрөг нь Мандах сумын ОНХС-ийн хөрөнгөөр Өехий багт юнителийн сүлжээний өргөтгөл барьсан урьдчилгаа олгосонтой тус тус холбоотой.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 7,089.7 сая төгрөг болж, өмнөх оноос 962.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл*

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>1,248.9</b>	<b>1,089.5</b>	<b>(159.4)</b>
Тусгай зориулалттай материал	659.9	563.0	(96.9)
Эм боох материал	589.0	526.5	(62.5)
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>275.0</b>	<b>89.7</b>	<b>(185.3)</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>4,414.5</b>	<b>5,736.4</b>	<b>1,321.9</b>
Бичиг хэргийн материал	121.2	143.2	22.0
Аж ахуйн материал	3,323.9	3,321.4	(2.5)

Сэлбэг хэрэгсэл	104.4	212.2	107.8
Түлш, шатах тослох материал	88.4	131.2	42.8
Барилгын засварын материал	1.5	2.0	0.5
Хүнсний материал	0.8	2.2	1.4
Бусад хангамжийн материал	774.3	1,924.2	1,149.9
<b>Мал амьтад</b>	<b>189.3</b>	<b>174.1</b>	<b>(15.2)</b>
<b>Дүн</b>	<b>6,127.7</b>	<b>7,089.7</b>	<b>962.0</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл байгаа 1,618.1 сая төгрөг нь Сайншанд сумын, 1,730.1 сая төгрөг нь Замын-Үүд сумын, 1,014.1 сая төгрөг нь Чандмань Илт ОНӨ ХХК-ийн, 222.1 сая төгрөг нь аймгийн Засаг даргын Тамгын газрын, 233.0 сая төгрөг нь Байгал орчны газрын, 255.7 сая төгрөг нь Өргөн сумын үлдэгдлүүд болон бусад сумд, харьяа байгууллагын бараа материалын үлдэгдлүүд байна.

#### Аудитын илрүүлэлт

- Сайхандулаан сумын Засаг даргын Тамгын газар: Тайлант хугацаанд нягтлан бодогч, эд хариуцагч өөрчлөгдөн томилогдсонтой холбоотой бараа материал, үндсэн хөрөнгийн тайланг баталгаажуулаагүйгээс өвс тэжээлийн орлогын тооцоо хийгээгүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.
- Сайхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит хуралдаанд оролцох 0.1 сая төгрөгийн шатахууныг байгууллагаас зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 10,224.9 сая төгрөг болж, өмнөх оноос 5,772.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	-	2,969.4	(2,969.4)
БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ	-	13,513.1	(13,513.1)
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>16,482.5</b>	<b>(16,482.5)</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,969.4 сая төгрөг нь “Мандах наран” хорооллын орон сууцны барилга, БЗЭБуй эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэл 13,513.1 сая төгрөг нь “Түрээсийн орон сууц” хөтөлбөрөөр иргэдэд түрээслүүлсэн орон сууцыг бүртгэж авсантай холбоотой байна.

### 3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 119,321.0 сая төгрөг болж, өмнөх оноос 6,537.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>106,206.2</b>	<b>112,038.9</b>	<b>5,832.7</b>
Барилга, байгууламж, орон сууц	48,954.7	55,913.5	6,958.8
Авто-тээврийн хэрэгсэл	5,340.8	6,753.9	1,413.1
Машин тоног төхөөрөмж(компьютер)	8,401.5	8,909.0	507.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,030.5	1,366.4	335.9
Зам, гүүрний байгууламж	7,404.7	9,337.9	1,933.2
Түүх соёл, музейн дурсалт зүйлс	48.7	48.7	-

Бусад үндсэн хөрөнгө	14,784.9	17,524.7	2,739.8
Дуусаагүй барилга, байгууламж	20,208.3	12,134.1	(8,074.2)
Ном	32.1	50.7	18.6
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>6,577.1</b>	<b>7,282.1</b>	<b>705.0</b>
Программ хангамж	126.9	86.2	(40.7)
Бусад биет бус хөрөнгө	6,450.1	7,195.9	745.8
<b>Дүн</b>	<b>112,783.3</b>	<b>119,321.0</b>	<b>6,537.7</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт 6,537.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд, шинээр худалдан авсан 1,841.9 сая төгрөгөөр, бүтцийн өөрчлөлтөөр шилжиж ирсэн хөрөнгө 9,215.6 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн авсан 1,112.6 сая төгрөгөөр, хандиваар 637.7 сая төгрөг дахин үнэлгээний нэмэгдэл 46.6 сая төгрөг, бусад 30,544.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Тус онд хөрөнгө худалдан борлуулсан 57.5 сая төгрөг, хөрөнгө акталсан 619.1 сая төгрөг, шилжүүлсэн 145.2 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилүүлсэн 9,336.7 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 40.1 сая төгрөг, бусад 18,981.9 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна. Бүтцийн өөрчлөлтийн шилүүлсэн нь 9,336.7 сая төгрөг нь Сайншанд сумын тохижилт Захирагчийн ажлын алба 2-ийг нийлүүлэн нэг байгууллага болгосонтой болсонтой холбоотой шилүүлэг байна.

Дуусаагүй барилга байгууламжийн дансны үлдэгдэл байгаа 12,134.1 сая төгрөгөөс 3,832.6 сая төгрөгийн аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ажил, 8,301.5 сая төгрөгийн улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажил бүртгэлтэй байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Алтанширээ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Тайлант онд жилийн эцсийн бараа материал болон үндсэн хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгээгүйд албан шаардлагыг хүргүүлсэн.
- Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газар: Тус шалгаагдагч байгууллагын хагас жилийн тооллогын баримттай танилцахад тооллогын комисс баталсан тушаал байхгүй, илтгэх хуудас байхгүй, тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй байсанд жилийн эцсийн тооллогыг чанартай гүйцэтгэх зөвлөмжийг завсрын аудитаар хүргүүлсэн.
- Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар: Тайлант онд ашиглах жил оруулаагүйгээс элэгдэл тооцоолоогүй, мөн ашиглах жил дууссан элэгдлийн зардлаар анхны өртөг нөхсөн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байсан зөрчилд зөвлөмжийг хүргүүлсэн.

#### Аудитын явцад залруулсан:

- Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газар: Тайланд онд худалдан авсан 266.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгахдаа ашиглах жил оруулаагүйгээс элэгдлийн зардал тооцоолоогүй алдааг залруулсан.
- Өргөн сумын Засаг даргын Тамгын газар: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 172.4 сая төгрөгийн бүрэн хэрэгжсэн 2 ажлыг данс бүртгэлд тусгаагүй, үндсэн хөрөнгийн бүртгэлд 9 нэр төрлийн хөрөнгөд ашиглагдах жил оруулаагүйгээс 9.3 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон, элэгдлийн эхний үлдэгдлийг 0.5 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн зэрэг алдааг аудитын явцад залруулсан.

### 3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 63,167.3 сая төгрөг болж, өмнөх оноос 30,106.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>254.9</b>	<b>177.8</b>	<b>(77.1)</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	8.8	24.7	15.9
Бараа үйлчилгээний зардлын өглөг	10.6	33.1	22.5
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	235.5	120.0	(115.5)
<b>Бусад өглөг</b>	<b>2,358.9</b>	<b>22,977.0</b>	<b>20,618.1</b>
Байгууллагад төлөх өглөг	1,100.5	3,730.9	2,630.4
Хувь хүмүүст төлөх өглөг	26.0	18.5	(7.5)
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.0	9.2	9.2
Татварын өглөг /ТӨҮГ/	219.8	279.1	59.3
Дансны өглөг /ТӨҮГ/	1,012.6	18,939.3	17,926.7
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>5,926.6</b>	<b>10,380.6</b>	<b>4,454.0</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>24,520.4</b>	<b>29,631.9</b>	<b>5,111.5</b>
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	10,224.9	11,627.5	1,402.6
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	14,295.5	18,004.4	3,708.9
<b>Дүн</b>	<b>33,060.8</b>	<b>63,167.3</b>	<b>30,106.5</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн өглөг данс 177.8 сая болж 77.1 сая төгрөгөөр буурсан нь татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг данс 120.0 сая төгрөг болж, 115.5 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна. Татаас санхүүжилт, шилжүүлгийн өглөг дансны үлдэгдэлд байгаа 120.0 сая төгрөг нь аймгийн ГХБХБГ-ийн нэмэлт санхүүжилтийн данс дахь үлдэгдлээ аймгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Бусад өглөг данс нь 22,977.0 сая төгрөг болж 20,618.1 сая төгрөгөөр өссөн нь ТӨҮГ-ийн дансны өглөг 17,926.7 сая төгрөг, аймгийн орон нутгийн орлого тасарсантай холбогдуулан аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний санхүүжилт 2,209.6 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна. Тус дансны үлдэгдэлд байгаа 18,939.3 сая төгрөг нь; Чандмань Илч ОНӨ ХХК-ийн 2,105.6 сая төгрөг, Эм эргэлтийн сан ОНӨУҮГ-ийн 308.8 сая төгрөг, Дорноговь орон сууц ОНӨ ХХК-ийн 16,524.3 сая төгрөг тус тус үлдэгдэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Чандмань-Илч ОНӨХХК-д шилжүүлсэн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөвт ажил 19,906.4 сая төгрөг, Дагшин- Эрдэнэ ОНӨХХК-ийн 16.4 сая төгрөг, аймгийн ерөнхий орлогын Азийн хөгжлийн банкны төслийн зээл 11,627.5 сая төгрөгийн урт хугацаат зээл тус тус бүртгэлтэй байна.

### 3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 125,303.0 сая төгрөг болж, өмнөх оноос 16462 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	19,295.4	19,297.4	2.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	22,675.7	23,148.2	472.5
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	523.5	523.5	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>65,925.3</b>	<b>65,286.7</b>	<b>(638.6)</b>
Өмнөх үеийн үр дүн	159,710.6	68,042.5	(91,668.1)
Тайлант үеийн үр дүн	-93,785.3	-2,755.8	91,029.5
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>17,047.3</b>	<b>17,047.2</b>	<b>(0.1)</b>
<b>Дүн</b>	<b>125,467.2</b>	<b>125,303.0</b>	<b>(164.2)</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын явцад залруулсан:

- Хөвсгөл сумын Хоршоог хөгжүүлэх сан: Тайлант үеийн үр дүнг 1.5 сая төгрөгөөр илүү тайлагнасныг аудитын явцад залруулсан.
- Хөвсгөл сумын Орон нутгийн хөгжлийн сан: Тайлант хугацаанд хэрэгжиж дуусаагүй 142.1 сая төгрөгийн 5 ТАХ-ний санхүүжилтийг дуусаагүй барилга дансанд бүртгээгүй, Засгийн газрын хувь оролцоо дансыг 26.5 сая төгрөгөөр буруу илэрхийлсэн. Мөн байгууллагад төлөх өглөгийг 29.6 сая төгрөгөөр илүү тайлагнасан алдааг аудитын явцад залруулсан.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Хүснэгт 10. Төсвийн орлого

Орлогын нэр төрөл	/сая төгрөгөөр/			
	Төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	Хувь
<b>I.НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>	120,058.4	94,161.2	(25,897.2)	78.4
<b>II.УРСГАЛ ОРЛОГО</b>	120,043.4	94,135.6	(25,907.9)	78.4
<b>III.ТАТВАРЫН ОРЛОГО</b>	111,840.4	86,950.4	(24,890.0)	77.7
<b>1.Орлогын албан татвар</b>	55,821.3	59,736.5	3,915.2	107.0
<b>1.1.Хувь хүний орлогын албан татвар</b>	33,911.3	34,753.4	842.1	102.5
1.1.1. Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад орлого	29,690.2	30,934.3	1,244.1	104.2
1.1.2. Үйл ажиллагааны орлогын татвар	2,017.9	1,483.5	(534.4)	73.5
1.1.3. Хадгаламжийн хүүгийн орлого	1,661.5	1,360.2	(301.3)	81.9
1.1.4. Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	737.4	1,016.3	278.9	137.8
1.1.5. Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	709.4	864.3	154.8	121.8
1.1.7. Хувь хүний орлогын албан татварын буцаалт	(905.2)	(905.2)	0.0	100.0
<b>1.2.ААН-ийн орлогын албан татвар</b>	21,910.0	24,983.1	3,073.1	114.0
1.2.1. ААН-ийн орлогын албан татвар	21,910.0	24,983.1	3,073.1	114.0
<b>2.ӨМЧИЙН АЛБАН ТАТВАР</b>	3,664.4	3,838.8	174.4	104.8
2.1. Үл хөдлөххөрөнгийн татвар	1,741.4	2,017.8	276.4	115.9
2.2. Галт зэвсгийн албан татвар	29.6	24.8	(4.8)	83.8
2.3. АТБӨЯХ-ийн албан татвар	1,071.3	1,313.7	242.4	122.6
2.4. Малын тоо толгойн албан татвар	822.2	482.6	(339.6)	58.7
<b>4. БУСАД ТАТВАР</b>	52,354.7	23,375.1	(28,979.6)	44.6
4.1. Улсын тэмдэгтийн хураамж	6,027.1	9,132.4	3,105.2	151.5
4.2. Газрын төлбөр	5,766.1	4,949.1	(817.0)	85.8
4.3. Дуудлага худалдааны орлого	37,516.0	6,464.3	(31,051.7)	17.2
4.4. Ан агнах зөвшөөрлийн хураамж	812.1	688.9	(123.3)	84.8
4.6. Рашаан, ус ашигласны төлбөр	880.1	1,032.5	152.3	117.3
4.7. Хог хаягдлын хураамж	543.0	487.3	(55.7)	89.7
4.9. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	810.2	620.8	(189.4)	76.6
<b>IV.ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	8,203.0	7,185.1	(1,017.9)	87.6
1. Түрээсийн орлого	30.0	76.7	46.7	255.6
2. Хүүгийн орлого	1,735.7	-	(1,735.7)	-
3. Торгуулийн орлого	2,263.7	2,245.8	(17.8)	99.2
4. Нэр зааж ангилалдаагүй орлого	3,870.7	4,461.4	590.7	115.3
5. Төсөвт байгууллагын өөрийн орлого	302.9	401.2	98.3	132.4
<b>V.ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	15.0	25.7	10.7	171.0
1. Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	15.0	25.7	10.7	171.0

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд татварын болон татварын бус орлогыг 120,058.4 сая төгрөгөөр төлөвлөснөөс 94,161.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 25,887.1 сая төгрөгөөр дутуу буюу гүйцэтгэл 78.4 хувьтай байна. Биелээгүй орлогын шалтгааныг авч үзвэл;

- Үйл ажиллагааны орлого болон Бичил худалдаа, ажил үйлчилгээний орлого эрхлэгч татвар төлөгчдөөс 2017.9 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн 1480.9 сая/төг-ийн орлого оруулж төлөвлөгөөг 73.4 хувь буюу 537.0 сая/төг-өөр орлогын төлөвлөгөө тасарсан. Замын-Үүд хилийн боомтоор улс хооронд ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэгч иргэд хязгаарлалттай тоогоор зорчсонтой холбоотой.
- Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татварын тооцохоо 1 хадгаламж зээлийн хоршоо, 1 банк бус санхүүгийн байгууллага, 13 банкны салбар тооцооны төв, нийт 15 татвар төлөгчөөс 1661.5 сая/төг-ийг төсвийн орлогот оруулахаар төлөвлөж 1379.9 сая/төг-ийн албан татварыг төвлөрүүлж 83.1 хувийн гүйцэтгэлтэйгээр орлогын төлөвлөгөө тасарсан. Зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалан иргэдийн хадгаламж буурсантай холбоотой.
- Галт зэвсгийн албан татварын орлогот 29.6 сая төгрөгөөр оруулахаар төлөвлөж 24.5 сая/төг-ийн албан татварыг төвлөрүүлж 83.0 хувь буюу 5.1 сая/төг-өөр орлогын төлөвлөгөө тасарсан. 170 татвар төлөгчдөд татвараа хуулийн хугацаанд төлөөгүйтэй холбоотой орлогын төлөвлөгөө тасарсан. Албан татварыг хугацаанд нь төлүүлэхээр бүх татвар төлөгчид масс мессежийг утас болон цахим хаягаар хүргүүлэн ажилласан.
- Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 822.2 сая/төг төвлөрүүлэхээс 478.8 сая/төгрөг төвлөрүүлж 58.2 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Говийн цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан малчид малаа арилжин борлуулах хүндрэл үүссэнтэй холбоотой орлогын төлөвлөгөө тасарсан.
- Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн албан татварт 812.1 сая/төгрөг төвлөрүүлэхээс 688.8 сая/төгрөгийг төвлөрүүлэн 84.8 хувийн гүйцэтгэлтэйгээр орлогын төлөвлөгөө тасарсан. Алтанширээ сум нэмэлт зөвшөөрлөөр 600.0 сая/төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 417.6 сая/төг-ийг төвлөрүүлж 182.4 сая/төг-өөр төлөвлөгөөг тасалснаас шалтгаалсан.
- Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг төлөвлөхдөө Газрын төлбөрийн хуулийн 11 төрөл тус бүр, урьд оны хүлээгдэж буй гүйцэтгэл, Сангийн Яамны хяналтын тоог үндэслэж 5766.1 сая төгрөгөөр төлөвлөсөн, 4926.2 сая/төг-ийг төсвийн орлого оруулж төлөвлөгөөг 85.4 хувь буюу 839.9 сая/төг-өөр орлогын төлөвлөгөө тасарсан. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа татвар төлөгчид үйл ажиллагаа эрхлээгүй, татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн зэрэг шалтгааны улмаар газрын төлбөрөө хуулийн хугацаанд төвлөрүүлээгүй.
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрлөөр 542.9 сая төгрөгийн албан татварыг төсвийн орлогот оруулахаар төлөвлөж 484.8 сая/төг-ийн албан татварыг төвлөрүүлж 89.3 хувь буюу 58.2 сая/төг-өөр орлогын төлөвлөгөөг тасалсан. Төсвийн орлогод төвлөрүүлэхээр тооцсон хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлбөрийг Хатанбулаг сум 39.5 сая/төг, Замын-Үүд сум 20.6 сая/төг-өөр дутуу төвлөрүүлсэн нь нөлөөлсөн.
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төрлөөр 810.2 сая төгрөгийн албан татварыг төсвийн орлогот оруулахаар төлөвлөж 620.8 сая/төг-ийн албан татварыг төвлөрүүлж 76.6 хувийн гүйцэтгэлтэй орлогын төлөвлөгөө тасарсан. Төсвийн орлогод төвлөрүүлэхээр тооцсон түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийг Сайншанд сум 82.3 сая/төг, Даланжаргалан сум 80.8 сая/төг, Өргөн сум 21.1 сая/төг-өөр дутуу төвлөрүүлсэн нь нөлөөлсөн.
- Дуудлага худалдааны орлого 37,516.0 сая төгрөгийн орлого оруулахаас 6,464.3 сая төгрөг оруулж биелэлт 17.2 хувьтай байгаа нь Монгол улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдийн хуралдаанаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулах асуудлыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд шинээр газар олгохгүй байхыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгасны дагуу БХБСайдын 2023 оны 1/2878 тоот албан бичгээр газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд шинээр газар олгох үйл ажиллагааг түр зогсоосон. Үүнтэй холбогдуулан Газрын биржийн цахим системд хаалт хийж, 3 сарын хугацаанд газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах боломжгүй болсон.

### 3.5.2 Төсвийн төлөвлөлт

Тус аймгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 17,702.0 сая төгрөг, орон нутгийн төсвийн орлогоос 39,465.8 сая төгрөг, нийт зарлагыг 57,167.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 28,928.4 сая төгрөгөөр бууруулж, 28,239.4 сая төгрөгөөр хянасан байна.

#### Аудитын илрүүлэлт:

- *Алтанширээ сумын Засаг дарга: Сумын татварын болон татварын бус нийт 15 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлийн дүнтэй харьцуулахад 87 хувийн биелэлттэй буюу 235.9 сая төгрөгөөр орлого тасарсан байна. Үүнээс шалтгаалан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх зарим ажил хэрэгжээгүй байдал үүссэн тул төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөхөөр зөвлөмжийг хүргүүлсэн.*

### 3.5.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор 36,808.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 19 хөтөлбөр, арга хэмжээг 163,640.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 97,416.1 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 25,571.4 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 2,531.5 сая төгрөг нийт 125,518.9 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүртгэж, нийт 133,119.2 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 133,119.2 сая төгрөг буюу 81.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг нийт 30,521.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Үүнд:

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	70105-Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	3,909.43	3,618.51	290.92	93
2	70709-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	402.61	381.19	21.42	95
3	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	140767.74	113510.45	27,257.29	81
4	70426-Төрийн өмчийг хэрэгжүүлэх	332.24	301.27	30.97	91
5	70418-Худалдан авах ажиллагаа	11.21	11.21	-	100
6	70429-Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	361.65	312.36	49.29	86
7	71413-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	2,628.86	2,499.10	129.76	95
8	71902-Нийгмийн халамж	146.4	94.6	51.80	65
9	71701-Биеийн тамир, спорт	507.86	485.51	22.35	96
10	71702-Соёл урлаг	1,451.85	1,335.44	116.41	92
11	71801-Сургуулийн өмнөх боловсрол	1,867.89	1,729.89	138.00	93
12	71802-Ерөнхий боловсрол	4,690.78	4,347.02	343.76	93
13	71804-Мэргэжлийн боловсрол	269.94	225.24	44.70	83
14	71602-Эрүүл мэнд	681.25	526.48	154.77	77
15	70801-Мал аж ахуйг хөгжүүлэх	420.5	420.17	0.33	100
16	70708-Гамшгаас хамгаалах	2,000.00	1,768.60	231.40	88
17	72208-Ахмад настны хөгжил, хамгаалал	70.49	70.49	-	100
18	71101-Автозам	1,384.20	1,181.63	202.57	85
19	70203-Засгийн газрын өрийн үйлчилгээ	1,735.71	300	1,435.71	17
<b>НИЙТ ДҮН</b>		<b>163,640.62</b>	<b>133,119.20</b>	<b>30,521.42</b>	<b>81</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### Аудитын илрүүлэлт:

- Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газар: Тайлант онд 12 албан хаагчдад нийт 6.4 сая төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг журмын дагуу нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас, ажлын цагийн тооцоо болон нэмэгдэл хөлс олгох шийдвэрийг гаргаагүй, анхан шатны баримтад үндэслээгүй олгосонд албан шаардлагыг хүргүүлсэн.
- Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газар: Тайлант оны 6, 7 дугаар сард Б.Баттамир, Т.Хурбаяр нарт сахилгын шийтгэл ногдуулсан бөгөөд 11 дүгээр сард хугацаанаас нь сахилгын шийтгэлгүйд тооцсон байна. Гэвч сахилгын шийтгэлтэй байх хугацаанд тус 2 албан хаагчид 0.6 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосныг төлбөрийн акт тогтоосон.
- Алтанширээ сумын н Засаг даргын Тамгын газар: Тайлант онд 22 албан хаагчид нийт 3.8 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон боловч нийгмийн даатгалын тайланд тусгаагүй зөрчилд зөвлөмжийг хүргүүлсэн.
- Алтанширээ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Тайлант онд албан хаагчдын 1.0 сая төгрөгийн цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд буруу илэрхийлсэнд албан шаардлагыг хүргүүлсэн.
- Алтанширээ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Тайлант онд албан хаагчдын 0.01 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг илүү олгосонд зөвлөмжийг хүргүүлсэн.
- Алтанширээ сумын Орон нутгийн хөгжлийн сан: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаадаагүй 11 төсөл, арга хэмжээг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжүүлсэнд зөвлөмжийг хүргүүлсэн.
- Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газар: Тайлант онд Үндсэн хуулийн өдөрт зориулж 0.9 сая төгрөгийг хуулиар хориглосон үйл ажиллагаанд зарцуулсанд зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг хүргүүлсэн.
- Даланжаргалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Тайлант онд Үндсэн хуулийн өдөрт зориулж 0.1 сая төгрөгийг, Хэлмэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөрт зориулж 0.2 сая төгрөгийг тус тус хуулиар хориглосон үйл ажиллагаанд зарцуулсанд зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг хүргүүлсэн.
- Даланжаргалан сумын Орон нутгийн хөгжлийн сан: Тайлант хугацаанд хэрэгжсэн ЭМТ-ийн барилгын дотор цэвэр ус, халаалт, агаар сэлгэлт, дохиолол холбоо, дотор цахилгааны ажлыг ИТХ-ын тогтоолоор батлуулаагүй 156.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн.
- Сайхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нөөц хөрөнгө арга хэмжээнд төсөв батлуулж, арга хэмжээ зохион байгуулах, дэмжлэг, шагнал урамшуулалд 11.4 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.
- Сайхандулаан сумын орон нутгийн хөгжлийн сан: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг тодотгох, зохицуулалт хийх замаар худалдан авах ажиллагаанд тусгаадаагүй төөл, арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчилд зөвлөмжийг хүргүүлсэн.
- Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар: Тайлант онд Нийгмийн даатгалын шимтгэлийг шилжүүлэхдээ ажил олгогчоос шилжүүлэх 2.7 сая төгрөгийг үндсэн цалингаас, шатахууны үнэ 0.4 сая төгрөгийг түлш халаалтын зардлаас шилжүүлсэн нийт 3.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- Өргөн сумын Засаг даргын Тамгын газар: Цалин хөлс тооцоолон олгохдоо 1 албан хаагчид 0.2 сая төгрөгийн хэвсран ажилласны нэмэгдлийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Өргөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Тайлант хугацаанд Монголын залуучуудын холбооны шагналаар шагнагдсан 1 албан хаагчид Монголын залуучуудын холбооны шагналын журмын үндэслэн 1.1 сая төгрөгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас өргөмжлөлийн хавтас хийлгэж 0.5 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг АҮТХ-ийн зардлаас шагналын зардалд 0.7 сая төгрөгийг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас 1.4 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага хүргүүлсэн.
- Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар: Тус байгууллагын Тамгын дарга Г.Тунгалагтуяа нь ажлын хэвийн нөхцөлд ажилладаг бөгөөд үндсэн 15 хоног дээр нэмэгдэл 14 хоногоор нийт 29 хоногийн ээлжийн амралтыг олгох байтал ээлжийн амралтыг 34 хоногоор тооцож 5 хоногийн 0.6 сая төгрөгийн олговрыг илүү тооцож олгосон. Уг олговрыг 7 сарын тооцсон цалингаас урьдчилж олгосон ээлжийн амралтыг суутгахдаа

1.3 сая төгрөгийг давхардуулан суутгасан байна. Иймд Г.Тунгалагтуяад 0.7 сая төгрөгийн цалинг буцаан олгох зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

- Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар: Тайлант онд ЗДТГ-ын даргын А/01-ны бүтэц орон тоо, цалингийн сан баталсан тушаалд мэдээлэл технологийн мэргэжилтэн нь үндсэн орон тоогоор баталсан байхад тухайн албан тушаалд гэрээтээр 2 хүнийг хөлсөөр ажиллуулах гэрээг байгуулан орон тоог давхардуулан ажиллуулж цалингийн зардалд 44.0 сая төгрөгийг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 5.5 сая төгрөгийг, нийт 49.5 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.
- Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар: Батлагдсан төсвийг зарцуулахдаа ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас цалингийн зардалд 4.7 сая төгрөгийг, цалингийн зардлаас 12.3 сая төгрөгийн мөнгөн шагналыг олгож, нийт 17.0 сая төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.
- Сайншанд сумын Захирагчийн ажлын алба: Тайлант онд цалингийн зардлаас 2.7 сая төгрөгийг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, урсгал засварын зардлаас 22.0 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд, бусдаар гүйцэтгүүлэх бусад НАУТХ-ийн зардлаас 0.5 сая төгрөгийг аудитын баталгаажуулалтын зардалд, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 1.0 сая төгрөгийг шуудан холбооны зардалд тус тус зориулалт бусаар зарцуулсанд аудитаар албан шаардлага хүргүүлсэн.
- Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газар: Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 10.0 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас 3.0 сая төгрөгөөр нийт 13.0 сая төгрөгөөр 1.000 боодол өвс худалдан авсан. Үүнийг 1 боодлыг 14.0 мянган төгрөгөөр малчдад борлуулснаас 10 боодол өвсийг малчинд үнэ төлбөргүй олгосон байна. Малчдад дараа тооцоогоор 2.9 сая төгрөгийн өвсийг, бэлэн мөнгөөр 10.8 сая төгрөгийг худалдан борлуулсан. Гэвч уг орлогыг төрийн сангийн харилцах дансанд байршуулалгүйгээр 10.0 сая төгрөгөөр тэжээл бэлтгэсэн зөрчилд албан шаардлага өгсөн.

#### Аудитын явцад залруулсан:

- Хөвсгөл сумын Орон нутгийн хөгжлийн сан: Өмнөх онд хэрэгжүүлсэн ТАХ-д илүү олгосон 6.2 сая төгрөгийн санхүүжилтийг туслах үйл ажиллагааны орлого дансанд буруу бүртгэсэн байсныг залруулсан.
- Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан худалдан авсан 11.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайлангийн бусад хөрөнгийн зардал дансанд тайлагнаагүй, нэмэлт дансанд буцаан олгосон өмнө оны үлдэгдэл төвлөрүүлэлт 2.0 сая төгрөгийг орлогоор тайлагнаагүй аудитаар тус тус залруулсан.
- Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Цалингийн зардлаас илүү шилжүүлсэн 0.9 сая төгрөгийн ХХОАТ-ыг бүртгээгүй, үр дүнгийн тайлангаар цалингийн зардлыг 1.6 сая төгрөгөөр илүү тайлагнасныг аудитаар залруулсан байна.
- Сайншанд сумын Захирагчийн ажлын алба: Тайлант оны цалингийн зардлыг 4.8 сая төгрөгөөр илүү, ажил олгогчоос төлөх НДШ-ийг 2.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитаар залруулсан.

#### **3.5.4 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 230.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 7,036.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,772.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: цалин хөлс 38.8 сая төгрөг, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл 1.0 сая төгрөг, байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 4.1 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 82.9 сая төгрөг, нормативт зардал 16.5 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 82.6 сая төгрөг, томилолт 24.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал 6,801.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,705.9 сая төгрөг, урсгал шилжүүлэг 36.6 сая төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 1,204.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд нийт 6 хөтөлбөрийн хүрээнд 1,090.0 сая төгрөгийн төсвийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 929.1 сая төгрөгийг зарцуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц 85.2 хувьтай дүгнэгдсэн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр /дэд хөтөлбөр/	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/сая төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	“Осол гэмтлээс сэргийлэх”	2020-2024	Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлнэ.	93.6%	80.0	71.3
2	“Англи хэлтэй Дорноговь” зорилтот хөтөлбөр	2021-2025	Англи хэлний сургалтын байгууллагын тоо өмнөх оноос 2-оор нэмэгдэж 6 болсон ба англи хэлний сургалтын хөтөлбөрт 3346 иргэнийг хамруулсан нь суралцагчдын тоо өмнөх оноос 23%-аар өссөн үр дүнтэй байна.	90.9%	100.0	91.1
3	“Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтот хөтөлбөр	2021-2025	хүүхэд эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын тогтвортой үр дүнд хүрэх	86.9%	400.0	330.1
4	“Монгол малчин” дэд хөтөлбөр	2020-2024	Малчдыг мэдээллээр хангах, хөгжүүлэх, орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, бүтээмж, орлого, ашгийг нь өсгөх, тэдгээрийг чадавхжуулах	90.0%	130.0	124.9
5	“Нээлттэй Дорноговь аймаг” зорилтот хөтөлбөр	2023-2024	Орон нутагт шилжин тогтвор суурьшилтай амьдарч, ажиллах гэр бүл, өрхөд чиглэсэн эдийн засгийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	91.1%	150.0	141.4
6	“Цахим Дорноговь” хөтөлбөр	2023-2026	“Ухаалаг засаглал” төрийн дотоод үйл ажиллагааг цахимжуулж уялдаа холбоог сайжруулах, төр, иргэн, аж ахуй нэгж хоорондын мэдээллийн урсгалыг сайжруулах, кибер аюулгүй байдлыг хангасан чадварлаг боловсон хүчнийг бэлтгэж нэгдсэн удирдлагын платформыг бий болгож ухаалаг засаглалын тогтолцоо бүрдүүлэх	59.0%	200.0	170.2
Нийт дүн				85.2	1,090.0	929.1

## **АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, зөрчил давтан гаргахгүй байх талаар албан шаардлагуудыг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Дэмбэрэлсүрэн, М.Дүүрэнжаргал, Н.Мөнхнасан нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор О.Нарангарав, аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 01/396 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгө сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 163,322.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,449.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 1,837.4 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аймгийн ТЕЗ-ын харьяа байгууллагуудад байгууллага тус бүр дээрээ холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Арга хэмжээнээс дурдвал Хэмнэлтийн тухай хуулийн 2 дугаар бүлэгт заасан Аймгийн Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглох, аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглох, эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглосон заалтууд болон байгууллагад бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэрийн өнгийг бүрэн сольж ажилласан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг зөрчсөн дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд; бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, хуульд тогтоомжид заагдаагүй урамшуулал олгосон, сургалт зохион байгуулсан, төсвийн хөрөнгөөр согтууруулах төрлийн ундаа авсан, тогтоосон хэмжээнээс илүү нормоор шатахуун зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрч холбогдох байгууллагуудад аудитын шийдвэрүүдийг хүргүүлсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Алтанширээ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Уралдаан тэмцээн зохион байгуулахад нийт 2.3 сая төгрөгийг зарцуулсанд албан шаардлагыг хүргүүлсэн.
- Даланжаргалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Тайлант онд сумын төсвийн орлогын гүйцэтгэл давж биелэгдсэний улмаас татварын байцаагч, газрын даамалд нийт 1.0 сая төгрөгийн хуульд тогтоомжид заагдаагүй урамшууллыг олгосон зөрчилд зөрчлийг давтахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн.
- Сайхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Тайлант онд дэвтэр, үзэг, бичгийн тавиур зэрэг бичиг хэргийн зардал 0.5 сая төгрөгийг, хоолны зардалд 0.1 сая төгрөгийг сургалт, зөвлөгөөн зохион байгуулах зорилгоор үр ашиггүй зарцуулсан зөрчилд зөвлөмжийг хүргүүлсэн.
- Сайхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны Б/29 дүгээр захирамжийг үндэслэн нэг удаагийн тэтгэмж, урамшууллын данснаас 0.2 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Өргөн сумын Засаг даргын Тамгын газар: Байгууллагын даргын 2023 оны А/134 дүгээр тушаалаар сумын нэгдсэн шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулах зардалд 0.1 сая төгрөгийн согтууруулах ундааны зардлыг батлан, байгууллагын төсвийн хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Агатова ӨЭМТ: Тайланд онд сургалт семинарын зардалд 0.8 сая төгрөгийг зарцуулсанд зөвлөмж хүргүүлсэн.
- Талст зам ӨЭМТ: Тайлант онд сургалт, хоолны зардалд 0.4 сая төгрөгийг зарцуулсанд зөвлөмж хүргүүлсэн.
- Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газар: Байгууллагын авто тээврийн хэрэгслийг ашиглах эрх бүхий этгээд боловч өдөрт заасан хэмжээнээс хэтрүүлж, 928.7 мянган төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.
- Борхойн наран өрхийн эрүүл мэндийн төв: Тайлант онд нийт 37.9 сая төгрөгийг шагнал урамшуулал, сургалт, сурталчилгааны зардалд зарцуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 2023 онд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 154 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл байна. Нийт засаг даргын 49,251.1 сая төгрөгийн 268 захирамж, 46,810.1 сая төгрөгийн 101 тендерийг мэдээлсэн байна.

Нэгтгэлд хамрагдсан харьяа байгууллагуудад шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрч аудитаар холбогдох шийдвэрүүдийг хүргүүлсэн байна. Үүнд;

#### Аудитын илрүүлэлт:

- Алтанширээ Засаг даргын Тамгын газар: Тайлант онд 820.1 сая төгрөгийн 35 орлогын гүйлгээ, 103.5 сая төгрөгийн 8 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн 126.3 сая төгрөгийн 32 шийдвэрийг байршуулаагүй байсанд албан шаардлага хүргүүлсэн.
- Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газар: Тайлант онд 66.6 сая төгрөгийн 4 орлогын гүйлгээ, 2.3 сая төгрөгийн 4 шийдвэрийг байршуулаагүйд нөхөн байршуулах зөвлөмжийг хүргүүлсэн.

- Даланжаргалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Тайлант онд 66.6 сая төгрөгийн 4 орлогын гүйлгээ, 2.3 сая төгрөгийн 4 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд нөхөн байршуулах зөвлөмжийг хүргүүлсэн.
- Даланжаргалан сумын Орон нутгийн хөгжлийн сан: Шилэн дансны системд ОНХС-тай холбоотой мэдээллийг төсвийн байгууллага хэсэгт буруу байршуулсан зөрчилд цаашид зөрчлийг давтахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн.
- Сайхандулаан сумын орон нутгийн хөгжлийн сан: Шилэн дансны системд шаардлагатай мэдээллийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар ТЕЗ-ийн санхүүгийн тайланд 5 горим сорил хэрэгжүүлж төлөвлөгөөг батлуулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	8.3	1	8.3	100
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>8.3</b>	<b>1</b>	<b>8.3</b>	<b>100</b>

/сая төгрөгөөр/

Өмнөх онд Засаг даргын бусад ангилагдаагүй нөөц хөрөнгийн зардлаас ИТХ-аар батлаагүй зардал болох Дорноговь Орон сууц ОНӨААТҮГ-т цалингийн зардалд 8.3 сая төгрөгийг олгосон төлбөрийн актыг барагдуулан ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжсэн 4 төсөл арга хэмжээний санхүүжилтэд орон нутгийн төсвөөс 3,755.1 сая төгрөгийг санхүүжүүлсэн байгаа нь улсын төсөвт аймгаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 43 төсвийн байгууллага, 10 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 30 тусгай сан, 14 төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан, нийт 97 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 97 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 47 байгууллагыг түүвэрт хамруулж, 50 байгууллагад дүгнэлт гаргаж “Өөрчлөлтгүй” 39, “Өөрчлөлттэй” 8 дүгнэлтийг хүргүүлсэн байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15,945.5 сая төгрөгийн 356 алдаа, зөрчил илрүүлснээс 15,052.1 сая төгрөгийн 192 алдааг залруулж, 10.2

сая төгрөгийн зөрчилд 19 төлбөрийн акт тогтоож, 463.4 сая төгрөгийн зөрчилд 64 албан шаардлага, 419.8 сая төгрөгийн зөрчилд 81 зөвлөмж өглөө.

#### Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 629.7 сая төгрөгийн 14 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 592.4 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 37.0 сая төгрөгийн 6 зөвлөмжийг хүргүүлсэн байна. 14 төсвийн төвлөрүүлэн захирагчид зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

#### Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн шууд захирагчийн 43 байгууллагаас 17 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 26 дүгнэлт өгсөн байна. Үүнээс өөрчлөлтгүй 20, өөрчлөлттэй 6 дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 8,739.5 сая төгрөгийн 219 алдаа, зөрчил илрүүлснээс 8,455.3 сая төгрөгийн 111 алдааг залруулж, 9.2 сая төгрөгийн зөрчилд 17 төлбөрийн акт тогтоож, 151.4 сая төгрөгийн зөрчилд 45 албан шаардлага, 123.6 сая төгрөгийн зөрчилд 46 зөвлөмж өгсөн.

#### Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа орон нутгийн өмчит 10 аж ахуйн нэгж байгууллагаас 4 байгууллага түүвэрт хамрагдаж, 6 байгууллагад дүгнэлт өгсөн байна. Үүнээс өөрчлөлтгүй 4, өөрчлөлттэй 2 /Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ, Борхойн баянбүрд ОНӨХХК/ дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 394.6 сая төгрөгийн 41 алдаа, зөрчил илрүүлснээс 50.4 сая төгрөгийн 15 алдааг залруулж, 297.6 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, 46.6 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсөн.

#### Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 30 сангийн 29 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 1 сангийн санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргасан.

Аудитаар нийт 6,073.3 сая төгрөгийн 81 алдаа, зөрчил илрүүлснээс 5,954.0 сая төгрөгийн 60 алдааг залруулж, 0.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 14.4 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 104.2 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсөн.

#### Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 2 зөрчил илрүүлж, 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

### **5.1 Зөвлөмж**

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Журам, гэрээний үлгэрчилсэн загвар шинэчлэн батлах тухай” журмын 3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсэгт “түрээслүүлэгч түрээсийн орлогын 50 хувийг байгууллагын нэмэлт орлогын дансанд, 50 хувийг ...” гэж заасан.

Энэхүү хэсэг нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-т “төсвийн орлого гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 47 дугаар зүйлийн 47.1.5-т “төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого”, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-т “төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого”

гэж заасныг тус тус зөрчсөн нь төсвийн байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны орлого бүрэн төвлөрөхгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Журам, гэрээний үлгэрчилсэн загвар шинэчлэн батлах тухай” журмын 3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсгийг хууль тогтоомж, холбогдох журамд нийцүүлэн батлуулах

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

### **5.2 Албан шаардлага**

Тайлант онд аймгийн хэмжээнд 5 сумын Засаг даргын Тамгын газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан уул уурхайн компани, аж ахуйн нэгжээс нийт 205.2 сая төгрөгийн хандив, тусламж хүлээн авч, сургалтын төлбөрийн дэмжлэг, багш нарт дэмжлэг үзүүлэх, баяр наадам зохион байгуулах, үндсэн хөрөнгө бэлтгэх зэргээр зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9-т “*Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж нь орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр байна*” гэж заасныг зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан		Залруул аагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Айраг сумын ХХС	1	12,750.95	-	-	1	12,750.95	-	-	1	12,750.95	-	-
Айраг сумын ОНХС	1	7,670,000.00	1	7,670,000.00	-	-	-	-	1	7,670,000.00	-	-
Алтанширээ сумын Засаг дарга	1	311,447,024.00	1	311,447,024.00	-	-	-	-	1	311,447,024.00	-	-
Алтанширээ сумын ХХС	1	300,000.00	1	300,000.00	-	-	-	-	1	300,000.00	-	-
Алтанширээ сумын ИТХ	2	1,214,000.00	1	240,000.00	1	974,000.00	-	-	2	1,214,000.00	-	-
Алтанширээ сумын ЗДТГ	1	16,961,662.00	-	-	1	16,961,662.00	-	-	1	16,961,662.00	-	-
Алтанширээ сумын ОНХС	2	915,971,382.92	1	306,247,024.00	1	609,724,358.92	-	-	2	915,971,382.92	-	-
Даланжаргалан сумын Засаг дарга	1	16,215,281.70	-	-	1	16,215,281.70	-	-	1	16,215,281.70	-	-
Даланжаргалан сумын ЗДТГ	3	27,709,446.60	2	27,105,000.00	1	604,446.60	-	-	3	27,709,446.60	-	-
Даланжаргалан сумын ИТХ	2	1,297,695.00	1	900,000.00	1	397,695.00	-	-	2	1,297,695.00	-	-
Даланжаргалан сумын ОНХС	2	168,912,075.00	1	159,933,275.00	1	8,978,800.00	-	-	2	168,912,075.00	-	-
Даланжаргалан сумын ХХС	2	12,487,857.00	1	11,382,189.00	1	1,105,668.00	-	-	2	12,487,857.00	-	-
Дэлгэрэх сумын ЗДТГ	8	33,213,543.00	5	32,403,501.00	3	810,042.00	-	-	8	33,213,543.00	-	-
Дэлгэрэх сумын ИТХ	2	41,047,900.00	-	-	2	41,047,900.00	-	-	2	41,047,900.00	-	-
Дэлгэрэх сумын ОНХС	4	141,230,514.00	2	124,010,000.00	2	17,220,514.00	-	-	4	141,230,514.00	-	-
Дэлгэрэх сумын ХХС	1	6,080,105.00	-	-	1	6,080,105.00	-	-	1	6,080,105.00	-	-
Иххэт сумын ЗДТГ	1	5,524,812.10	-	-	1	5,524,812.10	-	-	1	5,524,812.10	-	-
Иххэт сумын ИТХ	1	6,606,385.10	-	-	1	6,606,385.10	-	-	1	6,606,385.10	-	-
Иххэт сумын ОНХС	1	16,803,804.00	-	-	1	16,803,804.00	-	-	1	16,803,804.00	-	-
Мандах сумын ЗДТГ	1	20,941,996.00	-	-	1	20,941,996.00	-	-	1	20,941,996.00	-	-
Мандах сумын ИТХ	1	743,600.00	1	640,000.00	1	103,600.00	-	-	1	743,600.00	-	-
Мандах сумын ОНХС	2	678,351,839.00	1	310,372,000.00	1	367,979,839.00	-	-	2	678,351,839.00	-	-
Мандах сумын ХХС	2	344,847,578.48	-	-	1	344,847,578.48	-	-	2	344,847,578.48	-	-
Өргөн сумын ЗДТГ	5	232,729,524.88	3	50,440,000.00	2	182,289,524.88	-	-	5	232,729,524.88	-	-
Өргөн сумын ИТХ	1	248,000.00	1	248,000.00	-	-	-	-	1	248,000.00	-	-
Өргөн сумын ОНХС	5	583,455,950.00	1	399,221,642.00	4	184,234,308.00	-	-	5	583,455,950.00	-	-
Өргөн сумын ХХС	2	61,204,099.00	-	-	2	61,204,099.00	-	-	2	61,204,099.00	-	-
Сайхандулаан сумын Засаг дарга	1	11,500.00	-	-	1	11,500.00	-	-	1	11,500.00	-	-
Сайхандулаан сумын ЗДТГ	6	374,098,969.08	1	82,000,000.00	5	292,098,969.08	-	-	6	374,098,969.08	-	-

Сайхандулаан сумын ИТХ	2	19,255,776.00	19,255,776.00	-	-	2	-	2	-	19,255,776.00	-	-	-
Сайхандулаан сумын ОНХС	3	1,410,972,473.00	690,812,373.00	1	720,160,100.00	3	1	3	1	1,410,972,473.00	-	-	-
Сайхандулаан сумын ХХС	4	265,539,322.25	124,300,000.00	3	141,239,322.25	4	3	4	3	265,539,322.25	-	-	-
Улаанбадрах сумын ЗДТГ	4	16,482,258.60	5,115,397.85	3	11,366,860.75	4	3	4	3	16,482,258.60	-	-	-
Улаанбадрах сумын ИТХ	4	20,285,928.00	552,851.80	3	19,733,076.20	4	3	4	3	20,285,928.00	-	-	-
Улаанбадрах сумын ОНХС	3	331,278,900.00	186,395,000.00	2	144,883,900.00	3	2	3	2	331,278,900.00	-	-	-
Улаанбадрах сумын ХХС	2	1,957,328.64	-	2	1,957,328.64	2	2	2	2	1,957,328.64	-	-	-
Хатанбулаг сумын ЗДТГ	4	519,715,413.76	1,479,622.00	3	518,235,791.76	4	3	4	3	519,715,413.76	-	-	-
Хатанбулаг сумын ИТХ	4	47,472,313.70	17,110,671.20	2	30,361,642.50	4	2	4	2	47,472,313.70	-	-	-
Хатанбулаг сумын ХХС	3	780,864.59	502,392.40	2	278,472.19	3	2	3	2	780,864.59	-	-	-
Хөвсгөл сумын Засаг дарга	2	50,714,357.00	10,114,357.00	1	40,600,000.00	2	1	2	1	50,714,357.00	-	-	-
Хөвсгөл сумын ЗДТГ	4	23,513,560.82	-	3	23,513,560.82	4	3	4	3	23,513,560.82	-	-	-
Хөвсгөл сумын ОНХС	2	297,051,629.00	297,051,629.00	-	-	2	-	2	-	297,051,629.00	-	-	-
Хөвсгөл сумын ХХС	1	1,583,157.76	-	1	1,583,157.76	1	1	1	1	1,583,157.76	-	-	-
Эрдэнэ сумын ЗДТГ	3	57,457,836.86	2,581,800.00	2	54,876,036.86	3	2	3	2	57,457,836.86	-	-	-
Эрдэнэ сумын ИТХ	3	4,960,309.00	-	3	4,960,309.00	3	3	3	3	4,960,309.00	-	-	-
Эрдэнэ сумын ХХС	1	1,368,000.00	-	1	1,368,000.00	1	1	1	1	1,368,000.00	-	-	-
Сайншанд сумын ЗДТГ	2	936,110,025.20	-	2	936,110,025.20	2	2	2	2	936,110,025.20	-	-	-
Сайншанд сумын ИТХ	3	19,060,033.17	13,468,768.88	2	5,591,264.29	3	2	3	2	19,060,033.17	-	-	-
Сайншанд сумын ОНХС	2	94,755,536.00	-	2	94,755,536.00	2	2	2	2	94,755,536.00	-	-	-
Сайншанд сумын Захирагчийн ажлын алба	2	4,903,099,415.00	-	2	4,903,099,415.00	2	2	2	2	4,903,099,415.00	-	-	-
Агатовь ЗГБХН	2	2,057,814.42	107,814.42	1	1,950,000.00	2	1	2	1	2,057,814.42	-	-	-
Талст зам ЗГБХН	2	57,172,829.46	-	2	57,172,829.46	2	2	2	2	57,172,829.46	-	-	-
Мишээлт мана ЗГБХН	4	101,667,187.24	99,740,187.24	2	1,927,000.00	4	2	4	2	101,667,187.24	-	-	-
Замын-Үүд сумын Засаг дарга	1	213,980,143.00	-	1	213,980,143.00	1	1	1	1	213,980,143.00	-	-	-
Замын-Үүд сумын ЗДТГ	1	656,564,566.00	-	1	656,564,566.00	1	1	1	1	656,564,566.00	-	-	-
Замын-Үүд сумын ИТХ	2	611,725.00	-	2	611,725.00	2	2	2	2	611,725.00	-	-	-
Замын-Үүд сумын ОНХС	2	316,947,869.00	-	2	316,947,869.00	2	2	2	2	316,947,869.00	-	-	-
Замын-Үүд сумын ХХС	2	923,568.00	-	2	923,568.00	2	2	2	2	923,568.00	-	-	-
Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба	3	16,594.18	-	3	16,594.18	3	3	3	3	16,594.18	-	-	-
Борхойннарэн ЗГБХН	6	147,139,285.78	43,662.00	4	1,677,385.78	6	4	6	4	147,139,285.78	-	-	-
Борхойн баян бүрд ОНӨААТҮГ	6	35,984,277.88	298,484.00	2	2,452,645.88	6	2	6	2	35,984,277.88	-	-	-
Аймгийн ИТХ	6	147,139,285.78	43,662.00	4	1,677,385.78	6	4	6	4	147,139,285.78	-	-	-
Аймгийн ОНХС	6	6,896.00	6,896.00	-	-	6	-	6	-	6,896.00	-	-	-
Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	6	43,224.00	487,425.00	1	3,544,815.00	6	1	6	1	43,224.00	-	-	-
Чандмань Илч ОНӨХХК	6	5,646.00	5,646.00	-	-	6	-	6	-	5,646.00	-	-	-
Замын-Үүд НААУ ОНӨХХК	1	14,314,255.00	-	1	14,314,255.00	1	1	1	1	14,314,255.00	-	-	-
Дорноговь Орон сууц ОНӨААТҮГ	1	104,700.00	-	1	104,700.00	1	1	1	1	104,700.00	-	-	-
Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ	1	849.00	-	1	849.00	1	1	1	1	849.00	-	-	-

Байгаль орчин, аялал, жуулчлалын газар	5	3,649.00	-	-	5	3,649.00	5	3,649.00	-	-	-	-
Нийтлэг үйлчилгээний газар	1	2,442,533.00	-	-	1	2,442,533.00	1	2,442,533.00	-	-	-	-
Зүүнбаян Тохижилт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Зүүнбаян багийн Эрүүл мэндийн төв	4	10,694,290.00	-	-	4	10,694,290.00	4	10,694,290.00	-	-	-	-
Халамжийн сан Орон нутаг	3	293,472,000.00	-	-	3	293,472,000.00	3	293,472,000.00	-	-	-	-
<b>НИЙТ МӨНГӨН ДҮН</b>	<b>192</b>	<b>15,052,046,920.90</b>	<b>57</b>	<b>3,294,034,070.79</b>	<b>121</b>	<b>11,437,932,242.11</b>	<b>192</b>	<b>15,052,046,920.90</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил						Зөвлөмж						Акт						Албан шаардлага						Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ нэгтгэсэн тайлан	2	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Алтанширээ сумын Засаг дарга	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Алтанширээ сумын ИТХ	4	5,548,920.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Алтанширээ сумын ЗДТГ	5	12,272,278.00	-	-	-	2	4,714,800.00	-	-	1	562,500.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Даланжаргалан сумын ЗДТГ	4	6,687,190.00	-	-	-	3	5,773,090.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дэлгэрэх сумын ЗДТГ	1	894,524.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дэлгэрэх сумын ИТХ	1	800,000.00	-	-	-	1	800,000.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дэлгэрэх сумын ОНХС	1	667,445.00	-	-	-	-	-	-	-	1	667,445.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дэлгэрэх сумын ХХС	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Иххэт сумын Засаг дарга	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Иххэт сумын ОНХС	1	28,382,575.00	-	-	-	1	28,382,575.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Мандах сумын ЗДТГ	3	2,401,100.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Мандах сумын ОНХС	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Өргөн сумын Засаг дарга	2	18,000,000.00	-	-	-	1	18,000,000.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Өргөн сумын ЗДТГ	3	4,102,847.00	-	-	-	-	-	-	-	3	4,102,847.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Өргөн сумын ИТХ	2	1,100,000.00	-	-	-	-	-	-	-	1	1,100,000.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Өргөн сумын ХХС	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сайхандулаан сумын Засаг дарга	1	370,000.00	-	-	-	-	-	-	-	1	370,000.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сайхандулаан сумын ЗДТГ	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сайхандулаан сумын ИТХ	4	1,018,600.00	-	-	-	1	652,050.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сайхандулаан сумын ХХС	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Улаанбадрах сумын ЗДТГ	2	2,935,954.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Улаанбадрах сумын ИТХ	2	5,060,900.00	-	-	-	-	-	-	-	1	190,000.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Улаанбадрах сумын ХХС	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хатанбулаг сумын ЗДТГ	4	1,263,488.60	-	-	-	2	338,340.60	-	-	2	925,148.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хатанбулаг сумын ИТХ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хатанбулаг сумын ОНХС	2	74,964,934.00	-	-	-	2	74,964,934.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хөвсгөл сумын Засаг дарга	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хөвсгөл сумын ИТХ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хөвсгөл сумын ОНХС	2	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хөвсгөл сумын ХХС	1	900,000.00	-	-	-	1	900,000.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

(сая төгрөгөөр/)

Үүнээс



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил				Төлбөрийн акт				Үүнээс				Зөвлөмж
	Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
Алтанширээ сумын Засаг дарга	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Алтанширээ сумын ЗДТГ	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Алтанширээ сумын ОНХС	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Даланжаргалан сумын Засаг дарга	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Даланжаргалан сумын ЗДТГ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Даланжаргалан сумын ОНХС	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Өргөн сумын ЗДТГ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Улаанбадрах сумын ЗДТГ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хатанбулаг сумын ИТХ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хөвсгөл сумын ЗДТГ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэ сумын ИТХ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэ сумын ЗДТГ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сайншанд сумын ИТХ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Замын-Үүд сумын ЗДТГ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дэлгэрэх сумын ОНХС	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Мандах сумын ОНХС	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Хөвсгөл сумын ОНХС	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Сайншанд сумын Захирагчийн ажлын алба	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Борхойн баян бүрд ОНӨААТҮГ	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Орон нутгийн өмчийн газар	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ	1	13,062,500.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	13,062,500.00
Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Зүүнбаян Тохжилт	1	15,644,800.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	15,644,800.00
Зүүнбаян багийн Эрүүл мэндийн төв	1	35,456,400.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	35,456,400.00
Халамжийн сан Орон нутаг	1	1,389,000.00	-	-	-	-	-	-	-	-	-	-	1,389,000.00
<b>Дүн</b>	<b>26</b>	<b>148,052,700.00</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>6</b>	<b>-</b>	<b>20</b>	<b>148,052,700.00</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>													
Өргөн сумын ЗДТГ	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
Борхойн баян бүрд ОНӨААТҮГ	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Хамрын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа	1	10,171,500.00	-	-	-	-	-	-	-	-	-	1	10,171,500.00
Нийтлэг үйлчилгээний газар	1	14,776,100.00	-	-	-	-	-	-	-	-	-	1	14,776,100.00

/сая төгрөгөөр/

Зүүнбаян багийн Эрүүл мэндийн төв	3	30,930,770.00					3	30,930,770.00
Дүн	8	55,878,370.00	-	2	-	6	55,878,370.00	
Нийт дүн	34	203,931,070.00	-	8	-	26	203,931,070.00	



## ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2024/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: <a href="mailto:gan-ulzii.t@audit.gov.mn">gan-ulzii.t@audit.gov.mn</a>
Сайншанд	Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70503020 Цахим хаяг: <a href="mailto:oyuntulkhuur.u@audit.gov.mn">oyuntulkhuur.u@audit.gov.mn</a>
2024 он	Ахлах аудитор: О.Нарангарав Утас: 70523020 Цахим хаяг: <a href="mailto:narangarav.o@audit.gov.mn">narangarav.o@audit.gov.mn</a>
	Аудитор: Д.Дэмбэрэлсүрэн Утас: 70523020 Цахим хаяг: <a href="mailto:demberelsurend@audit.gov.mn">demberelsurend@audit.gov.mn</a>
	Аудитор: М.Дүүрэнжаргал Утас: 70523020 Цахим хаяг: <a href="mailto:duurenjargalm@audit.gov.mn">duurenjargalm@audit.gov.mn</a>
	Аудитор: Н.Мөнхнасан Утас: 70523020 Цахим хаяг: <a href="mailto:munkhnasanN.@audit.gov.mn">munkhnasanN.@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>ТАЙЛАНГИЙН АГУУЛГА</b>	
<u>Тайланг бэлтгэсэн:</u>	
Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгийн тайлбар .....3
Дарга, тэргүүлэх аудитор:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй .....4
<b>Т.Ган-Өлзий</b>	Ерөнхий мэдээлэл ..... 5
Аудитын менежер:	БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ..... 6
<b>У.Оюунтүлхүүр</b>	БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ.....11
Ахлах аудитор:	БҮЛЭГ 3: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ .....13
<b>О.Нарангарав</b>	БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ .....17
Аудитор:	ДҮГНЭЛТ: ..... 19
<b>Д.Дэмбэрэлсүрэн</b>	
<b>М.Дүүрэнжаргал</b>	
<b>Н.Мөнхнасан</b>	
2024 оны 04 сарын 19	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70522734, 70503020 дугаарын утас, <a href="mailto:dornogovi@audit.gov.mn">dornogovi@audit.gov.mn</a> хаягаар харилцана уу.	
ХАЯГ:Дорноговь аймаг, Сайншанд сум, Төрийн өмчийн 3 дугаар байр.	

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УИХ	Улсын Их Хурал
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
НСС	Нөхөн сэргээлтийн сан
ОН	Орон нутаг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗГНХ	Засгийн газрын нэмэлт хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЗАА	Захирагчийн ажлын алба
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
МУ	Монгол Улс
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
НҮГ	Нийтлэг үйлчилгээний газар
НТБ	Насан туршийн боловсрол

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд, тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн гүйцэтгэв.

### Аудитын зорилт

Дорноговь аймгийн ТӨЗ-ийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалган, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт
- Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл
- Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

Аудитад улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого

### Аудитын хамрах хүрээ

байгууллага, аж ахуйн нэгж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ.

### Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд MNS 6817-5:2020 санхүүгийн аудитын зарчим, арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга тодруулга авах, тайлан бусад баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор О.Нарангарав, аудитор Н.Мөнхнасан нар гүйцэтгэв.

### Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлүүлж, тайланг 04 дүгээр сарын 19-ны өдөр дуусган, Үндэсний аудитын газар, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлээ.

**Ерөнхий мэдээлэл:**

Сангийн яамнаас Дорноговь аймгийн 2023 оны суурь орлогыг 56,790.6 сая төгрөг, суурь зарлагыг 28,239.4 сая төгрөгөөр хянаж, улсын төсөвт 8,783.7 сая төгрөг төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардалд 19,767.6 сая төгрөгийг зарцуулахаар, тэнцлийг 28,551.3 сая төгрөг байхаар баталсан байна.

Төсвийн тодотголоор суурь орлогыг 69,855.3 сая төгрөг, суурь зарлагыг 31,670.6 сая төгрөгөөр хянаж, улсын төсөвт 16,015.4 сая төгрөг төвлөрүүлэхээр, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардалд 22,169.4 сая төгрөгийг зарцуулахаар, тэнцлийг 38,184.8 сая төгрөг байхаар төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 10/06 дүгээр тогтоол болон сумдын ИТХ-ын “2023 оны орон нутгийн төсөв баталсан” тогтоолоор орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 93,312.3 сая, төсвийн ерөнхий харилцах дансны оны эхний үлдэгдлээс 250.0 сая, **нийт санхүүжилтийг 93,562.3 сая төгрөгөөр**, урсгал зардлыг 44,964.0 сая, аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 8,783.7 сая, хөрөнгө оруулалтын зардлыг 39,814.5 сая, **нийт зарлагыг 93,562.3 сая төгрөгөөр** тус тус баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12/05 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын 2023 оны “2023 оны орон нутгийн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах” тогтоолоор орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 120,058.4 сая, төсвийн ерөнхий харилцах дансны оны эхний үлдэгдлээс 4,007.5 сая, **нийт санхүүжилтийг 124,065.9 сая төгрөгөөр**, урсгал зардлыг 57,107.9 сая, аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 16,015.4 сая, хөрөнгө оруулалтын зардлыг 50,942.5 сая, **нийт зарлагыг 124,065.9 сая төгрөгөөр** тус тус тодотгон, орлого зарлагыг 26,746.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, тодотгож баталсан байна.

Тайлант хугацаанд аймаг, сумдын төсөвт 1 удаа тодотгол, жилийн эцэст 1 удаа зохицуулалт хийсэн ба орон нутгийн төсвийн суурь орлогын 93.2 хувийг татварын орлогоор, 6.8 хувийг татварын бус орлогоор бүрдүүлэхээр баталсан байна.

Аймгийн 2023 оны төсвийн нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 126,832.2 сая төгрөгөөр баталж, 36,808.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 163,640.6 сая төгрөг болгож тодотгон, төсвийн зохицуулалтыг хийж баталсан байна.

Аймгийн төсөвт хийгдсэн тодотгол болон төсвийн зохицуулалтаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөнд дараах өөрчлөлтүүдийг хийсэн байна.

Үүнд: ОН-ийн төсвийн санхүүжилтийг 26,696.4 сая, ОНХНС-аас аймгийн төсөвт олгох орлогын шилжүүлгийг 4,338.7 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогын санхүүжилтийг 49.7 сая, тусгай сангуудын орлогыг 721.5 сая, урьд оны үлдэгдлийн санхүүжилтийг 5,002.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

## БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.1. Дорноговь аймгийн 2023 оны төсвийн суурь орлогыг МУ-ын Төсвийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйлийн 58.2-т заасан нөхцөл, чиг үүрэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн 38,035.8 сая төгрөгийн төсвийн санал боловсруулж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

УИХ-аас 2022 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр баталсан МУ-ын 2023 оны Төсвийн тухай хуулиар аймгийн 2023-ны орон нутгийн төсвийн суурь орлогыг 56,790.6 сая төгрөгөөр буюу төсвийн саналаас 18,754.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Сангийн яамнаас хянаж ирүүлсэн суурь орлогыг аймаг болон сумдын ИТХ-ын 2022 оны "2023 оны төсөв батлах тухай" тогтоолуудаар нийт 93,312.3 сая төгрөгөөр, үүнээс татварын орлогыг 88,653.8 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 4,658.4 сая төгрөгөөр буюу суурь орлогыг нийт 36,521.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

**Орон нутгийн төсвийн суурь орлого - Анхны төсөв**

*Хүснэгт №1*

Орлогын төрөл	2022 онд хүргүүлсэн төсвийн санал	Сангийн яамны хянасан орлого	ИТХ-аар баталсан орлого			Нэмэгдүүлсэн
			Аймгийн дүн	Сумын дүн	Нийт дүн	дүн
Татварын орлого	31,307.3	53,591.1	47,666.5	40,987.4	88,653.8	35,062.7
Татварын бус орлого	6,728.5	3,199.6	2,729.9	1,928.5	4,658.4	1,458.9
<b>ДҮН</b>	<b>38,035.8</b>	<b>56,790.6</b>	<b>50,396.4</b>	<b>42,915.9</b>	<b>93,312.3</b>	<b>36,521.6</b>

*/сая төгрөг/*

УИХ-ын 2023 оны 06 дүгээр сарын 16-ны өдрийн 2023 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг 13,064.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 69,855.3 сая төгрөгөөр баталж, төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

2023 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтэй уялдуулан аймаг, сумдын төсөвт 1 удаа төсвийн тодотгол, жилийн эцэст 1 удаа төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн тодотголын суурь орлогыг аймаг, сумдын ИТХ-ын 2023 оны төсвийн тодотгол болон төсвийн зохицуулалтаар нийт 120,058.4 сая төгрөгөөр, үүнээс татварын орлогыг 111,862.6 сая төгрөг, татварын бус орлогыг 8,195.9 сая төгрөгөөр буюу суурь орлогыг 50,203.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Төсвийн тодотголоор орон нутгийн орлогын батлагдсан төсвийг нийт 26,746.1 сая төгрөгөөр, үүнээс татварын орлогыг 23,208.7 сая төгрөг, татварын бус орлогыг 3,537.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

**Орон нутгийн төсвийн суурь орлого – Тодотгосон төсөв**

*Хүснэгт №2*

Орлогын төрөл	Сангийн яамны хянасан орлого	ИТХ-аар баталсан орлого			Нэмэгдүүлсэн
		Аймгийн дүн	Сумын дүн	Нийт дүн	дүн
Татварын орлого	66,655.8	60,471.3	51,391.3	111,862.6	45,206.8
Татварын бус орлого	3,199.6	5,585.4	2,610.5	8,195.9	4,996.3
<b>ДҮН</b>	<b>69,855.3</b>	<b>66,056.6</b>	<b>54,001.8</b>	<b>120,058.4</b>	<b>50,203.1</b>

*/сая төгрөг/*

МУ-ын Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "Жилийн төсвийн хязгаар гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн ТЕЗ-ийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээ" гэж заасан.

Гэтэл орон нутгийн суурь орлогын баталсан доод хэмжээг баримтлахгүйгээр хувь хүнээс суутгасан орлогын албан татварыг 162.6 сая төгрөгөөр, бууны албан татварыг 2.4 сая төгрөгөөр, газрын төлбөрийг 9,567.7 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

Орон нутгийн төсвийн суурь орлогын 93.2 хувийг татварын орлогоос, 6.8 хувийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр баталсан байна.

Төсвийн тодотголоор аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 66,056.6 сая төгрөгөөр буюу 15,660.2 сая, сумдын төсвийн орлогын төлөвлөгөөг 54,001.8 сая төгрөгөөр буюу 11,085.9 сая, орон нутгийн нийт орлогыг 120,058.4 сая төгрөгөөр буюу 26,746.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

**Орон нутгийн төсвийн суурь орлого**

Хүснэгт №3	/сая төгрөг/		
	Батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Өөрчлөлт
<b>Аймгийн төвийн орлого</b>	50,396.4	66,056.6	15,660.2
<b>Сумдын орлого</b>	42,915.9	54,001.8	11,085.9
<b>ОН-ийн орлогын дүн</b>	<b>93,312.3</b>	<b>120,058.4</b>	<b>26,746.1</b>

Орлогын төлөвлөгөөний өөрчлөлтийг авч үзэхэд: цалин хөлс, түүнтэй адилтгах бусад орлогыг 9,143.0 сая, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 12,810.0 сая, хадгаламжийн хүүгийн орлогыг 10.4 сая, хүний орлогын албан татварын орлогын буцаан олголтыг 5,2 сая, үл хөдлөх хөрөнгийн татварыг 5.0 сая, малын тоо толгойн албан татварыг 8.9 сая, улсын тэмдэгтийн хураамжийг 2,350.4 сая, ан агнах зөвшөөрлийн хураамжийг 452.5 сая, хог хаягдлын хураамжийг 26.2 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 66.8 сая, торгуулийн орлогыг 544.1 сая, нэр зааж ангилагдаагүй орлогыг 2,965.7 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 49.7 сая төгрөгөөр **тус тус нэмэгдүүлж**, үйл ажиллагааны орлогын албан татварыг 1,382.0 сая, хувь хүнээс суутгасан орлогын албан татварыг 8.6 сая, хөрөнгө борлуулсны орлогын албан татварыг 16.5 сая, галт зэвсгийн албан татварыг 1.3 сая, газрын төлбөрийг 273.1 сая төгрөгөөр **тус тус бууруулж** баталсан байна.

Тайлант хугацаанд сумдын төсвийн орлогыг нэмэгдүүлж баталсан төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзэхэд орлогын хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн тооцоо судалгаагүйгээр нэмэгдүүлж, бууруулсан байна.

Хог хаягдлын хураамж, малын тоо толгойд ногдуулсан татвар, газрын төлбөр зэрэг татварын хэмжээг нь сумын ИТХ-аар баталдаг, мөн холбогдох байгууллагаас ногдуулалт хийж тогтоодог эдгээр орлогыг тодотголоор нэмэгдүүлж, бууруулан баталж байгаа нь орлогыг бодитой төлөвлөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Сангийн яамны хянасан суурь орлогыг аймаг, сумдын ИТХ-аас баталсан төсвөөр суурь орлогыг 2022 онд 64,877.0 сая төгрөгөөр, 2023 онд 50,203.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан бөгөөд өмнөх оноос 22.6 хувиар буурсан байна.

Орон нутгийн төсвийн 2023 оны орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл татварын орлогыг 10,354.2 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 2,391.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, өмнөх оноос нийт 12,745.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

**Орон нутгийн төсвийн суурь орлого**

Д/д	Орлогын нэр төрөл	Орлого		/сая төгрөг/ Зөрүү
		2022	2023	
		1	Татварын орлого	
2	Орлогын албан татвар	24,920.9	33,919.9	8,999.0
3	Хувь хиний орлогын албан татвар	25,725.7	34,825.1	9,099.4
4	Хувь хиний орлогын албан татварын	-804.8	-905.2	-100.4

буцаан олголт				
5	ААН-ийн орлогын албан татвар	6,610.0	21,910.0	15,300.0
6	Хөрөнгийн албан татвар	3,264.7	3,659.8	395.1
7	Бусад татвар, төлбөр, хураамж	66,690.6	52,350.7	-14,339.9
8	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,635.4	7,398.2	1,762.8
9	Газрын төлбөр	7,831.2	5,744.3	-2,086.9
10	Дуудлага худалгаа	52,401.1	37,516.0	-14,885.1
11	Байгалийн нөөц ашигласны төлбөр	822.9	1,692.2	869.3
12	Татварын бус орлого	5,826.5	8,218.0	2,391.5
13	Нийтлэг татварын бус орлого	5,796.5	8,203.0	2,406.5
14	Хөрөнгийн орлого	30.0	15.0	-15.0
<b>Нийт орлогын дүн</b>		<b>107,312.7</b>	<b>120,058.4</b>	<b>12,745.7</b>

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор аймгийн **2023 оны орон нутгийн төсвийн зардлыг санхүүжүүлэх нийт эх үүсвэрийг** 126,832.2 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор нийт 36,808.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, **163,640.6 сая төгрөгөөр баталсан байна.**

**2023 оны орон нутгийн төсвийн нийт санхүүжүүлэх**

Хүснэгт №5

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Батлагдсан төсөв			
		Анх батлагдсан	Тодотгосон	Зохицуулалт	өөрчлөлт
1	Татварын орлого	88,653.8	111,862.6	111,840.4	23,186.6
2	Татварын бус орлого	4,405.2	7,892.9	7,915.1	3,509.9
3	Өөрийн орлого	253.2	302.9	302.9	49.7
4	ОНХНС-ийн санхүүжилт	22,531.6	26,870.3	26,870.3	4,338.7
5	ОНХС - орлого	207.0	792.3	792.3	585.3
6	ХХС - орлого	877.7	1,013.9	1,013.9	136.2
7	НСС - орлого	36.5	36.5	36.5	-
8	ОНХС - урьд оны үлдэгдлээс санхүүжих	7,721.5	8,927.4	8,927.4	1,205.9
9	ХХС - урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,625.2	1,659.3	1,659.3	34.2
10	НСС - урьд оны үлдэгдлээс санхүүжих	270.5	275.0	275.0	4.5
11	ЕД-ны урьд оны үлдэгдлээс санхүүжих ОНХО	250.0	4,007.5	4,007.5	3,757.5
<b>Нийт орлого</b>		<b>126,832.2</b>	<b>163,640.6</b>	<b>163,640.6</b>	<b>36,808.4</b>

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон ИТХ-аар баталсан төсвийн өөрчлөлтөөр аймгийн төсвийн орлогын эх үүсвэрийн төлөвлөгөөнд дараах өөрчлөлтүүдийг хийсэн байна. Үүнд: ОН-ийн төсвийн санхүүжилтийг 26,696.4 сая, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогын санхүүжилтийг 49.7 сая, ОНХНС-аас аймгийн төсөвт олгох орлогын шилжүүлгийг 4,338.7 сая, тусгай сангуудын орлогыг 721.5 сая, урьд оны үлдэгдлийн санхүүжилтийг 5,002.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

**1.2.** Дорноговь аймгийн 2023 оны төсвийн нийт зарлагыг 83,384.0 сая төгрөгөөр төлөвлөн төсвийн санал боловсруулж, Сангийн яаманд хүргүүлж, Сангийн яамнаас 2023 оны төсвийн орон нутгийн суурь зарлагыг 28,239.4 сая төгрөгөөр буюу төсвийн саналаас 55,144.6 сая төгрөгөөр бууруулж, 2023 оны төсвийн тодотголоор суурь зарлагыг 31,670.6 сая төгрөг байхаар хянасан байна.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “*Жилийн төсвийн хязгаар гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн ТЕЗ-ийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээ*” гэж заасан.

Сангийн яамнаас хянаж ирүүлсэн суурь зарлагыг аймаг, сумдын ИТХ-ын 2022 оны “2023 оны төсөв батлах тухай” тогтоолоор нийт 56,539.2 сая төгрөгөөр, 2023 оны төсвийн тодотголын суурь зарлагыг нийт 76,379.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн орон нутгийн зарлагыг нийт 108,050.5 сая төгрөгөөр баталсан байна.

**Орон нутгийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөө**

Хүснэгт №6

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Сангийн яамны хянасан төсөв		ИТХ-аар баталсан			төсвийн зохицуулалт	
	2022.11.15	2023.06.16	Анхны төсөв	Төсвийн тодотгол	Зөрүү	Төсвийн зохицуулалт	Зөрүү
Аймгийн ИТХ	491.9	491.9	1,686.1	2,098.9	412.8	2,098.9	-
Сумын ИТХ	1,163.1	1,163.1	1,593.2	2,213.2	620.0	2,213.2	-
Аймгийн ЗДТГ	6,431.3	9,862.5	6,116.5	7,018.9	902.3	6,480.1	(538.8)
Сумын ЗДТГ	7,264.4	7,264.4	9,895.6	13,679.3	3,783.8	13,629.3	(50.0)
Хот тохижуулах газар	828.6	828.6	1,363.1	1,643.4	280.3	1,643.4	-
Захирагчийн ажлын алба	-	-	3,011.4	3,961.5	950.1	3,961.5	-
ОНӨГазар	182.0	182.0	279.9	343.5	63.5	332.2	(11.2)
ОН-ХАА-ны газар	-	-	-	-	-	11.2	11.2
БОГазар	1,203.0	1,203.0	1,712.8	1,875.0	162.2	1,879.5	4.4
СХАА	193.4	193.4	284.5	361.2	76.8	361.7	0.4
НХҮХэлтэс	146.4	146.4	146.4	146.4	-	146.4	-
Засаг дарга – Урсгал зардал	2,097.7	2,097.7	4,978.8	7,640.5	2,661.7	8,002.4	361.9
Засаг дарга /Хөрөнгийн зардал/ - ОНХО	-	-	39,814.5	50,942.5	11,128.0	50,942.5	-
НҮГ	-	-	887.8	1,070.8	183.0	1,084.3	13.5
Насан туршийн боловсрол	-	-	89.4	-	(89.4)	-	-
ОНБ-уудын үйлчилгээ ашиглалт	9,437.9	9,437.9	10,330.4	10,511.6	181.2	9,469.6	(1,042.0)
Гадаад зээл тусламжийн эргэн төлөлт	(1,200.5)	(1,200.5)	(1,200.5)	(1,200.5)	-	-	1,200.5
Аймгийн ОНХСанд олгох санхүүжилт	-	-	-	-	-	-	-
Сумдын ОНХСанд олгох санхүүжилт	-	-	882.5	1,670.6	788.0	1,720.6	50.0
Замын Үүд сумын орон нутгийн хөрөнгө оруулалт	-	-	2,548.0	3,619.6	1,071.6	3,619.6	-
Замын Үүд сумын ойн анги	-	-	358.3	454.1	95.9	454.1	-
<b>Орон нутгийн суурь зарлага</b>	<b>28,239.4</b>	<b>31,670.6</b>	<b>84,778.5</b>	<b>108,050.5</b>	<b>23,271.9</b>	<b>108,050.5</b>	<b>-</b>

Сангийн яамны хянасан орон нутгийн төсвийн суурь зарлагын тодотгосон төлөвлөгөөг аймаг, сумдын ИТХ-аар баталсан төсвийн тодотгол болон төсвийн зохицуулалтаар хийгдсэн өөрчлөлтийг авч үзэхэд аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын урсгал зардлыг 23,716.8 сая, сумдын ОНХС-д олгох орон нутгийн орлогын санхүүжилтийг 1,720.6 сая, ОНХО-ын зардлыг 50,942.5 сая төгрөгөөр, нийт 76,379.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн нийт зарлагыг 84,778.5 сая төгрөгөөр батлан, төсвийн нэмэлт өөрчлөлтөөр нийт 23,271.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 108,050.5 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн 2023 оны төсвийн зарлагын төлөвлөгөөг өмнөх оны төлөвлөгөөтэй харьцуулж үзэхэд 13 төрлийн зардлыг нийт 19,206.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 5 төрлийн зардлыг 12,068.4 сая төгрөгөөр бууруулсан байх ба орон нутгийн зарлагын төлөвлөгөө өмнөх оноос нийт дүнгээрээ 7,138.3 сая төгрөгөөр өссөн байна.

**Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө**

Хүснэгт №7

/сая төгрөг/

Д/д	Зарлагын төрөл	2022 он	2023 он	Өөрчлөлт
1	Аймаг, сумын ИТХ	2,740.5	4,312.0	1,571.5
2	Аймаг, сумын ЗДТГ	14,707.5	20,109.4	5,401.9
3	Хот тохижуулах газар	2,748.7	1,643.4	-1,105.3
4	Захирагчийн ажлын алба	422.9	3,961.5	3,538.6
5	Орон нутгийн өмчийн газар	225.3	332.2	106.9

6	Худалдан авах ажиллагааны газар	0.0	11.2	11.2
7	Байгаль орчныг хамгаалах газар	1,350.9	1,879.5	528.6
8	Санхүүгийн хяналт, аудитын алба	228.0	361.7	133.7
9	Халамжийн сан	146.4	146.4	0.0
10	Засаг дарга-Урсгал зардал	4,530.7	8,002.4	3,471.7
11	Засаг дарга-Хөрөнгийн зардал	55,200.7	50,942.5	-4,258.2
12	НҮГ	729.3	1,084.3	355.0
13	Насан туршийн боловсрол	89.4	0.0	-89.4
14	ОНБ-уудын үйлчилгээ ашиглалт	10,187.5	9,469.6	-717.9
15	Гадаад зээл тусламжийн эргэн төлөлт	-2,106.0	0.0	2,106.0
16	Аймгийн ОНХСанд олгох санхүүжилт	5,897.6	0.0	-5,897.6
17	Сумдын ОНХСанд олгох санхүүжилт	1,306.9	1,720.6	413.7
18	Замын Үүд сумын орон нутгийн хөрөнгө оруулалт	2,293.0	3,619.7	1,326.7
19	Замын Үүд сумын ойн анги	212.9	454.1	241.2
<b>Нийт дүн</b>		<b>100,912.2</b>	<b>108,050.5</b>	<b>7,138.3</b>

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг Сангийн яамнаас хянасан дүнгээр буюу аймгийн ИТХ-ын 2022 оны “2023 оны төсөв батлах тухай” тогтоолоор нийт 8,783.7 сая төгрөгөөр, 2023 оны төсвийн тодотголоор 7,231.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн **16,015.4 сая төгрөгөөр баталсан байна.**

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор аймгийн **2023 оны төсвийн нийт зардлыг** 126,832.2 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор нийт 36,808.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, **163,640.6 сая төгрөгөөр баталсан байна.** Үүнд: Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын урсгал зардлыг 42,298.2 сая, тусгай сангуудын зардлыг 41,295.3 сая, ОНХО-ын зардлыг 54,562.2 сая, орон нутгийн байгууламжийн үйлчилгээ ашиглалтын зардлыг 9,469.5 сая, улсын төсөвт татан төвлөрүүлэх орлогыг 16,015.4 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

**2023 оны орон нутгийн төсвийн нийт зардал**

Хүснэгт №8

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Батлагдсан төсөв			
		Анх	Тодотгосон	Зохицуулалт	Өөрчлөлт
1	АИТХ	1,686.1	2,098.9	2,098.9	412.8
2	СИТХ	1,593.2	2,213.2	2,213.2	620.0
3	АЗДТГ	6,116.5	7,018.9	6,480.1	363.6
4	СЗДТГ	9,895.6	13,679.3	13,629.3	3,733.8
5	Хот тохижилт	1,363.1	1,643.4	1,643.4	280.3
6	Захирагчийн ажлын алба	3,011.4	3,961.5	3,961.5	950.1
7	ОНӨГазар	279.9	343.5	332.2	52.3
8	Худалдан авах ажиллагаа	-	-	11.2	11.2
9	БОГазар	1,712.8	1,875.0	1,879.5	166.7
10	СХАА	284.5	361.2	361.7	77.2
11	НХҮХэлтэс	146.4	146.4	146.4	-
12	НҮГ	887.8	1,070.8	1,084.3	196.5
13	Насан туршийн боловсрол	89.4	-	-	(89.4)
14	ОНБ-уудын үйлчилгээ ашиглалт	10,330.4	10,511.6	9,469.6	(860.8)
15	Гадаад зээл тусламжийн эргэн төлөлт	(1,200.5)	(1,200.5)	-	1,200.5
16	Засаг дарга	4,978.8	7,640.5	8,002.4	3,023.7
17	Аймгийн ОНХОруулалт	39,814.5	50,942.5	50,942.5	11,128.0
18	Замын Үүдийн орон нутгийн хөрөнгө оруулалт	2,548.0	3,619.6	3,619.6	1,071.6
19	Замын Үүдийн ойн анги	358.3	454.1	454.1	95.9
20	Улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг	8,783.7	16,015.4	16,015.4	7,231.7
21	ОНХС-д орон нутгийн орлогоос олгох	882.5	1,670.6	1,720.6	838.0
22	ОНХС-д олгох бусад санхүүжилт	30,460.1	36,590.0	36,590.0	6,129.9
23	ХХС	2,502.9	2,673.3	2,673.3	170.4
24	НСС	307.0	311.5	311.5	4.5
<b>Нийт зардал</b>		<b>126,832.2</b>	<b>163,640.6</b>	<b>163,640.6</b>	<b>36,808.4</b>

Төсвийн тодотгол, төсвийн зохицуулалтаар аймгийн төсвийн зарлагын төлөвлөгөөнд дараах өөрчлөлтүүдийг хийсэн байна. Үүнд: аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын урсгал зардлыг 11,095.0 сая, тусгай сангуудын зардлыг 7,142.8 сая, ОНХО-ын зардлыг 12,199.7 сая, улсын төсөвт татан төвлөрүүлэх орлогыг 7,231.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, орон нутгийн байгууламжийн үйлчилгээ ашиглалтын зардлыг 860.8 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

## БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

**2.1.** Аймгийн орон нутгийн төсвийн орлогыг 120,058.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 94,161.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн, 25,897.2 сая төгрөгөөр тасарч, орлогын төлөвлөгөө 78.4 хувиар биелсэн байна.

*Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл*

Орлогын нэр төрөл	Тайлант он							
	Аймгийн орлого		Сумдын орлого		Төсвийн нийт орлого		Төлөвлөгөө гүйцэтгэлийн	
	Төл-гөө	Гүй-гэл	Төл-гөө	Гүй-гэл	Төл-гөө	Гүй-гэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	60,471.2	33,978.6	51,369.2	52,971.8	111,840.4	86,950.4	24,890.0	77.7
Татварын бус орлого	5,585.4	4,950.8	2,632.6	2,260.0	8,218.0	7,210.8	1,007.2	87.7
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>66,056.6</b>	<b>38,929.4</b>	<b>54,001.8</b>	<b>55,231.8</b>	<b>120,058.4</b>	<b>94,161.2</b>	<b>25,897.2</b>	<b>78.4</b>

Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг авч үзэхэд татварын орлого 56.2 хувь, татварын бус орлого 88.6 хувь, **нийт хэрэгжилт 58.9 хувьтай**, сумдын орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзэхэд татварын орлого 103.1 хувь, татварын бус орлого 85.8 хувь, **нийт хэрэгжилт 102.3 хувьтай** байна.

Татварын болон татварын бус орлогын нэр төрлөөрх биелэлтийн тайлбарыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитад дэлгэрэнгүй тусгасан болно.

Орлогын төлөвлөгөөний биелэлт 78.4 хувь байгаа нь Алтанширээ, Иххэт, Өргөн, Сайншанд сумдын болон аймгийн орлогын төлөвлөгөө нийт 58,719.4 сая төгрөгөөр тасарсан нь тус тус нөлөөлсөн бөгөөд энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх үүрэг хүлээнэ" гэсэн заалтын дагуу Өргөн, Сайншанд сумд аймагт татан төвлөрүүлэх орлогыг, аймаг улсад төсөвт төвлөрүүлэх орлогыг тус тус бүрэн төвлөрүүлээгүй байна.

Орлого тасрахад голчлон нөлөөлсөн орлого нь аймгийн дуудлага худалдааны орлого бөгөөд нийт 31,051.7 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь БХБС-ын 2023 оны 1/2878 тоот албан бичгээр газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд шинээр газар олгох үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотой газрын биржийн цахим системд хаалт хийж 3 сарын хугацаанд газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах боломжгүй болсонтой холбоотой байна.

Сумдын орон нутгийн орлогоос аймгийн төсөвт 2023 онд татан төвлөрүүлэх орлогын хэмжээг 24,861.7 сая төгрөг байхаар баталж, 28,932.1 сая төгрөг болгон тодотгож гүйцэтгэлээр 31,810.7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 2,878.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 6 сум 6,290.5 сая төгрөгийг илүү, 2 сум 3,412.0 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Хөвсгөл, Эрдэнэ сумд аймгаас нийт 149.6 сая төгрөгийн татаас санхүүжилтийн дэмжлэг авахаар батлагдсан ч оны эцэст сумдын орон нутгийн татвар төлөвлөгөөнөөс давж аймгийн төсөвт нийт 861.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Сумдын төсөөс аймгийн төсөвт татан төвлөрүүлсэн санхүүжилт

Хүснэгт №10

/сая төгрөг/

Д/д	Сумын нэр	Төсөвт төвлөрүүлэх орлого			Зөрүү /Илүү -, Дутуу+ /
		Бат/төсөө	Тод/төсөө	төвлөрүүлсэн санхүүжилт	
1	Алтанширээ	208.3	59.6	59.6	-
2	Даланжаргалан	4,215.2	4,071.7	4,598.8	(527.1)
3	Мандах	237.4	78.2	117.5	(39.3)
4	Өргөн	528.0	379.9	367.0	12.9
5	Хатанбулаг	541.6	528.0	1,454.4	(926.4)
6	Хөвсгөл	-	-	759.6	(759.6)
7	Эрдэнэ	-	-	101.7	(101.7)
8	Сайншанд	11,634.8	14,071.5	10,672.4	3,399.1
9	Замын-Үүд	7,496.5	9,743.3	13,679.7	(3,936.4)
<b>Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын дүн</b>		<b>24,861.7</b>	<b>28,932.1</b>	<b>31,810.7</b>	<b>(2,878.6)</b>

2.2. Тайлант онд аймгийн ТЕЗ түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагааны орлогыг 302.9 сая төгрөгөөр төлөвлөж, хэрэгжилт 1.3 дахин их буюу 401.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №11

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Сумдын ЗДТГ	37.0	53.4	(16.4)	144.3
2	Захирагчийн ажлын алба	52.0	77.1	(25.1)	148.3
3	Аймгийн Засаг даргын харьяа байгууллагууд	213.9	270.7	(56.8)	126.6
<b>Нийт дүн</b>		<b>302.9</b>	<b>401.2</b>	<b>(98.3)</b>	<b>132.5</b>

Аймгийн ТЕЗ-ийн харьяа 16 байгууллагын орлого 110.1 сая төгрөгөөр давж, 5 байгууллагын орлого 11.9 сая төгрөгөөр тасарсан байна.

2.3. Аймгийн төсвийн орлогын эх үүсвэр нийт 163,640.6 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 121,862.9 сая төгрөгийг бүрдүүлэн, төлөвлөгөөний биелэлт 74.5 хувьтай байна.

Орлогын эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №12

/сая төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв			Төсвийн гүйцэтгэл	Төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү
	Анх батлагдсан	Сүүлийн төсөв /зохицуулалт хийгдсэн/	Төсөвт орсон нийт өөрчлөлт		
Татварын орлого	88,653.8	111,840.4	23,186.6	86,950.4	24,890.0
Татварын бус орлого	4,405.2	7,915.1	3,509.9	6,809.6	1,105.5
Төсөвт байгууллагуудын өөрийн орлого	253.2	302.9	49.7	401.2	-98.3
ОНХНС-ийн санхүүжилт	22,531.6	26,870.3	4,338.7	25,571.4	1,298.9
Тусгай сангуудын орлого	1,121.2	1,842.7	721.5	2,130.3	-287.6
Урьд оны үлдэгдлээс санхүүжих -Тусгай сангууд	9,617.2	10,861.7	1,244.6	0.0	10,861.7
ЕД-ны урьд оны үлдэгдлээс санхүүжих	250.0	4,007.5	3,757.5	0.0	4,007.5
<b>Нийт орлого</b>	<b>126,832.2</b>	<b>163,640.6</b>	<b>36,808.4</b>	<b>121,862.9</b>	<b>41,777.7</b>

Нийт орлогын эх үүсвэрийн 76.9 хувийг татварын болон татварын бус орлого, 21.0 хувийг ОНХС-ийн санхүүжилт, 2.1 хувийг үйл ажиллагааны орлогын санхүүжилт тус тус эзэлж байна.

Аймаг сумдын ИТХ-ын тогтоолоор ОНХС-ийн бусад орлогыг 792.3 сая төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлэх хөрөнгийг 1,013.9 сая төгрөг, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх барьцаа хөрөнгийг 36.5 сая төгрөгөөр тус тус төлөвлөж, гүйцэтгэлээр ОНХС-ийн бусад орлого 892.2 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлого 1,026.5 сая төгрөг, нөхөн сэргээлтийн тусгай дансны барьцаа хөрөнгөөс 211.6 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

**Тусгай сангуудын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

Хүснэгт №13 / сая төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Орлогын гүйцэтгэл	Зөрүү
Хоршоо хөгжүүлэх сан	1,013.9	1,026.5	(12.6)
Нөхөн сэргээлтийн сан	36.5	211.6	(175.1)
Орон нутгийн хөгжлийн сан	792.3	892.2	(99.9)
<b>Нийт</b>	<b>1,842.7</b>	<b>2,130.3</b>	<b>(287.6)</b>

ОНХС-ийн орлого 99.9 сая төгрөгөөр, ХХС-ийн орлого 12.6 сая төгрөгөөр, НСС-ийн тусгай дансны орлого 175.1 сая төгрөгөөр тус тус давсан байна. Энэ нь хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт болон хугацаа хэтэрсэн зээлийн төлөлтийг шүүхийн шийдвэрээр барагдуулсантай холбоотой байна. Мөн сумдад хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хугацаанд нь батлуулж барьцаа хөрөнгийг байршуулсантай холбоотойгоор НСС-ийн орлого давж биелсэн байна.

### БҮЛЭГ 3: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

**3.1.** Дорноговь аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн нийт суурь зарлагыг 108,050.5 сая төгрөгөөр тодотгож баталснаас 87,344.1 сая төгрөг буюу 80.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Орон нутгийн зарлагын гүйцэтгэл**

Хүснэгт №14 / сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Сангийн яамны хянасан төсөв	Аймаг сумдын ИТХ-аар баталсан	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аймгийн ИТХ	491.9	2,098.9	2,009.0	89.8
2	Сумын ИТХ	1,163.1	2,213.2	1,990.7	222.5
3	Аймгийн ЗДТГ	9,862.5	6,480.1	4,585.2	1,894.9
4	Сумын ЗДТГ	7,264.4	13,629.3	12,742.4	886.9
5	Хот тохижуулах газар	828.6	1,643.4	1,569.9	73.5
6	Захирагчийн ажлын алба	-	3,961.5	3,533.2	428.3
7	ОНӨГазар	182.0	332.2	301.3	31.0
8	Худалдан авах ажиллагаа	-	11.2	11.2	0.0
9	БОГазар	1,203.0	1,879.5	1,786.7	92.7
10	СХАА	193.4	361.7	312.4	49.3
11	НХҮХэлтэс	146.4	146.4	94.6	51.8
12	Засаг дарга-Урсгал зардал	2,097.7	8,002.4	6,663.6	1,338.8
13	Засаг дарга-Хөрөнгийн зардал	-	50,942.5	36,878.3	14,064.2
14	НҮГ	-	1,084.3	1,067.2	17.1
15	ОНБ-уудын үйлчилгээ ашиглалт	9,437.9	9,469.6	8,649.6	820.0
16	Гадаад зээл тусламжийн эргэн төлөлт	(1,200.5)	-	-	-
17	Сумдын ОНХСанд олгох санхүүжилт	-	1,720.6	1,111.8	608.7
18	Замын Үүд сумын орон нутгийн хөрөнгө оруулалт	-	3,619.6	3,590.9	28.8
19	Замын Үүд сумын ойн анги	-	454.1	446.1	8.0
	<b>Орон нутгийн суурь зарлага</b>	<b>31,670.6</b>	<b>108,050.5</b>	<b>87,344.1</b>	<b>20,706.4</b>

Орон нутгийн нийт суурь зардлын 37,113.5 сая төгрөгийг харьяа төсөвт байгууллагуудын зарцуулалт, 8,649.6 сая төгрөгийг ОНӨ-т байгууламжийн ашиглалтын зардал, 1,111.8 сая төгрөгийг сумдын ОНХС-д олгосон санхүүжилт, 40,469.2 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын зардалд тус тус зарцуулсан байна.

Орон нутгийн нийт суурь зарлага 20,706.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь орон нутгийн татварын болон татварын бус орлого нийт дүндээ 25,897.2 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

**3.2.** Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 22,531.5 сая төгрөгийг олгохоор баталж, төсвийн тодотголоор 4,338.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 26,870.3 сая төгрөгөөр батлан, гүйцэтгэлээр 25,571.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

**ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт**

Хүснэгт №15				/сая төгрөг/
№	Эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ОНХНС-аас олгох	26,870.3	25,571.4	1,298.9
2	Бусад орлого /хандив/	792.3	892.2	(99.9)
3	Орон нутгийн төсвийн орлогоос санхүүжих	1,720.5	1,111.8	608.7
4	Оны эхний үлдэгдлээс	8,927.4	-	8,927.4
<b>Дүн</b>		<b>38,310.5</b>	<b>27,575.4</b>	<b>10,735.1</b>
1	<b>ОНХС-ийн зарцуулалт</b>	<b>38,310.5</b>	<b>34,567.7</b>	<b>3,742.8</b>
	<i>МХ-н эхний үлдэгдэл</i>	-	9,817.5	-
	<i>МХ-н эцсийн үлдэгдэл</i>	-	2,825.2	-

ОНХНС-аас аймгийн ОНХС-д 18,602.1 сая төгрөгөөс 17,250.6 сая төгрөгийн, сумдын ОНХС-д 8,268.2 сая төгрөгөөс 8,320.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвийн орлогоос сумдын ОНХС-д 1,720.6 сая төгрөгөөс 1,111.8 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон нийт санхүүжилт 27,575.4 сая төгрөг байна.

ОНХС-ын зардлын нийт гүйцэтгэл 34,567.7 сая төгрөг буюу 90.2 хувийн биелэлттэй, өмнө оны үлдэгдлээс 6,992.3 сая төгрөгийг зарцуулан жилийн эцэст 2,825.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**ХХС болон НСС-ийн зарцуулалт**

Хүснэгт №16				/сая төгрөг/				
Үзүүлэлт	Батлагдсан төсөв			Орлогын гүйцэтгэл	Зөрүү	Нийт гүйцэтгэл	МХ-н эхний үлдэгдэл	МХ-н эцсийн үлдэгдэл
	Оны эхний үлдэгдэл ээс	Тайлант оны орлогоос	Нийт					
Хоршоо хөгжүүлэх сан	1,659.3	1,013.9	<b>2,673.3</b>	1,026.5	12.6	1,821.0	2,062.3	1,267.7
Нөхөн сэргээлтийн сан	275.0	36.5	<b>286.4</b>	211.6	175.1	24.9	366.6	553.3
<b>Нийт</b>	<b>1,934.3</b>	<b>1,050.4</b>	<b>2,984.7</b>	<b>1,238.1</b>	<b>187.7</b>	<b>1,845.9</b>	<b>2,428.8</b>	<b>1,821.0</b>

Тайлант онд ХХС-ийн зардлын гүйцэтгэл 1,821.0 сая төгрөг байгаагаас 1,811.5 сая төгрөгийг шинээр зээл олгоход, 9.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,062.3 сая төгрөг байна. Харин НСС-ийн зардлын гүйцэтгэл 24.9 сая төгрөгийг зориулалтын дагуу үйл ажиллагаанд зарцуулсан бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 553.3 сая төгрөг байна.

**3.3.** Дорноговь аймгийн 2023 оны төсвийн нийт зарлага /аймаг, сумдын нийт дүнгээр/ тодотгосон төсвөөр 163,640.6 сая төгрөгөөр батлагдсанаас 133,119.2 сая төгрөг буюу 81.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Зардлын гүйцэтгэл /эдийн засгийн ангиллаар/**

Хүснэгт №17

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2023 он			
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>86,074.4</b>	<b>163,640.6</b>	<b>133,119.2</b>	<b>30,521.5</b>	<b>81.3</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>53,435.9</b>	<b>109,078.4</b>	<b>92,649.7</b>	<b>16,428.8</b>	<b>84.9</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	10,678.2	16,600.0	15,687.5	912.5	94.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,469.6	2,151.4	1,942.3	209.1	90.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,480.8	10,334.8	9,439.1	895.7	91.3
Хангамж, бараа материалын зардал	1,240.7	1,807.8	1,652.4	155.3	91.4
Нормативт зардал	171.4	223.7	220.4	3.4	98.5
Эд хогшил, урсгал засварын зардал	1,358.5	2,044.7	1,882.1	162.6	92.0
Томилолт, зочны зардал	199.9	302.5	256.6	45.9	84.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,451.2	13,867.9	11,957.0	1,910.9	86.2
Бараа үйлчилгээний бусад зардал	1,199.2	3,560.6	2,744.0	816.6	77.1
Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	946.3	1,735.7	300.0	1,435.7	17.3
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	50.0	300.0	294.0	6.0	98.0
Урсгал шилжүүлэг	21,190.1	56,149.3	46,274.2	9,875.1	82.4
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>32,638.5</b>	<b>54,562.2</b>	<b>40,469.5</b>	<b>14,092.7</b>	<b>74.2</b>

Орон нутгийн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг авч үзвэл бараа, үйлчилгээний зардал 34.8 хувь, урсгал шилжүүлэг 34.8 хувь, хөрөнгийн зардал 30.4 хувийн гүйцэтгэлтэй буюу нийт зардлыг 30,521.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Зарим зардлын хэмнэлтийн шалтгааныг авч үзвэл дараах байдалтай байна.

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал нийт дүнгээр 912.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь аймгийн ЗДТГ, ИТХ болон харьяа орон нутгийн төсвийн байгууллагууд бүтэц орон тоогоор бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй улмаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын нэмэгдэл хэмнэлт үүссэн.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 895.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх зорилт 1.15.1-д “сумдыг төвлөрсөн дулаан хангамжид үе шаттай холбох” заалтын дагуу алслагдмал 10 сумыг төвлөрсөн шугамд холбож ашиглалтад оруулж, 2023 онд Сайншанд сумын ЕБ-н 2 дугаар сургуулийн өргөтгөл, Хатанбулаг сумын 320 хүүхдийн сургууль, Замын-Үүд 640 хүүхдийн сургууль ашиглалтад ороогүйн улмаас тогтмол зардалд хэмнэлт үүссэн, Төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж сургууль, цэцэрлэгийг ажиллахгүй байгаа үед цахилгаанаар халдаг горимд шилжүүлэх, сургууль, цэцэрлэгийн халаах талбайн хязгаарлалт хийх гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлэх арга хэмжээ авч ажилласнаар хэмнэгдсэн.
- Бусад зардлын хэмнэлт нь Төрийн хэмнэлтийн хуулийн 7 дугаар зүйл, 9 дүгээр зүйл, 12 дугаар зүйл, 15 дугаар заалтын 15.2.3 сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх, заалтуудыг хэрэгжүүлж эд хогшил, урсгал засвар, дотоод томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж, төвлөрүүлэх арга хэмжээ авч ажилласантай холбоотой байна.
- Мөн аймгийн орлого тасарсантай холбоотой байгууллагууд болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

**3.4.** Тайлант онд аймгийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 10,039.1 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнээс: дээд шатны төсвийн захирагчаас 7,036.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,772.8 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрсөн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос цалин хөлсний зардалд 38.8 сая төгрөг, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 1.0 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 4.1 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 83.0 сая төгрөг, нормативт зардалд 16.6 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 82.6 сая төгрөг, томилолтын зардалд 24.3 сая төгрөг, бусад зардалд 8,507.1 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 36.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 40.1 сая төгрөгийг тус тус зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 1,204.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл**

Хүснэгт №18

№	Зардлын үзүүлэлт	Дүн	Үзүүлэлт	Тайлант он	/сая төгрөг/
1			Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		38.8
2			Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1.0
3			Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		4.1
4			Хангамж, бараа материалын зардал		83.0
5	УРСГАЛ ЗАРДАЛ	9,999.0	Нормативт зардал		16.6
6			Эд хогшил, урсгал засварын зардал		82.6
7			Томилолт, зочны зардал		24.3
8			Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,801.1
9			Бараа үйлчилгээний бусад зардал		1,705.9
10			Урсгал шилжүүлэг		1,241.5
11	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40.1	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		40.1
<b>Нийт дүн</b>					<b>10,039.1</b>

3.5. Аймгийн төсвөөс 7 суманд 1,597.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор баталж, төсвийн тодотголоор 574.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2,172.0 сая төгрөгөөр баталснаас 5 суманд 1,563.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.

**Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг**

Хүснэгт №19

Д/д	Сумын нэр	Санхүүгийн дэмжлэг			Зөрүү
		Бат/төсөв	Тод/төсөв	олгосон санхүүжилт	
1	Айраг	102.9	113.6	69.0	44.7
2	Дэлгэрэх	385.7	538.3	478.5	59.8
3	Иххэт	318.7	469.2	358.8	110.4
4	Сайхандулаан	380.4	548.3	406.9	141.4
5	Улаанбадрах	176.1	353.0	250.7	102.3
6	Хөвсгөл	100.2	0.4	-	0.4
7	Эрдэнэ	133.8	149.3	-	149.3
Нийт дүн		<b>1,597.8</b>	<b>2,172.0</b>	<b>1,563.8</b>	<b>608.2</b>

Тайлант онд сумдын орон нутгийн төсвийн орлого нийт 988.9 сая төгрөгөөр давж биелсэнтэй сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 608.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Үүнээс 2 суманд 149.7 сая төгрөгийн дэмжлэгийг олгоогүй, дэмжлэг олгосон 5 суманд 458.5 сая төгрөгийг дутуу олгосон байна.

3.6. Аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 16,015.4 сая төгрөгийг баталснаас гүйцэтгэлээр 10,473.1 сая төгрөг төвлөрүүлж, **5,542.3 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн** нь тайлант оны орон нутгийн татварын болон татварын бус орлого нийт 25,897.2 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

Мөн тайлант онд орон нутгийн төсвөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 4 төсөл арга хэмжээний санхүүжилтэд 3,755.1 сая төгрөгийг олгосон нь улсын төсөвт аймгаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн байна.

3.7. Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтад нийт 54,562.1 сая төгрөгийн төсөв батлагдаж 40,469.2 сая төгрөгийг зарцуулан, 74.2 хувьтай биелсэн байгаа нь орон нутгийн орлогын төлөвлөгөө биелээгүй, ТАХ-г хэрэгжүүлэгч байгууллагууд ажлаа бүрэн хийж

дуусгаагүй зэрэг шалтгаан нөлөөлсөн байна.

**Дорноговь аймагт хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл**

Хүснэгт №20 /сая төгрөг/

Төсөв захирагч	Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжүүлэх дүн	Олгосон санхүүжилт	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
Аймаг	142	50,942.5	36,878.3	14,064.2	72.4
Замын-Үүд сум	37	3,619.6	3,590.9	28.7	99.2
<b>Нийт дүн</b>	<b>130</b>	<b>54,562.1</b>	<b>40,469.2</b>	<b>14,092.9</b>	<b>74.2</b>

**БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ**

Сангийн яамны хянасан төсвөөр аймгийн орон нутгийн орлого зардлын тэнцлийг 38,943.3 сая төгрөгөөр, аймгийн ИТХ-ын баталсан төсвөөр 12,007.9 сая төгрөгөөр тус тус батлан гүйцэтгэлээр 6,817.1 сая төгрөгийн тэнцэлтэй, улсын төсвийн орлогод 10,473.1 сая төгрөгийг төвлөрүүлж, жилийн эцэст аймгийн ерөнхий орлогын дансанд 351.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

**Аймгийн орон нутгийн төсвийн 2023 оны тэнцэл**

Хүснэгт №21 /сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Сангийн яамны хянасан төсөв	Аймгийн ИТХ-аар баталсан	Гүйцэтгэл	Зөрүү
	<b>Оны эхний харилцах дансны үлдэгдэл</b>		<b>4,007.5</b>	<b>4,007.5</b>	
	<b>Орон нутгийн суурь орлого</b>	<b>69,855.3</b>	<b>120,058.4</b>	<b>94,161.2</b>	<b>25,897.2</b>
1	Татварын орлого	66,655.8	111,840.4	86,950.4	24,890.0
2	Татварын бус орлого	3,190.7	7,915.1	6,809.6	1,105.5
3	ТЭЗ, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого	8.9	302.9	401.2	(98.3)
	<b>Орон нутгийн суурь зарлага</b>	<b>30,912.1</b>	<b>108,050.5</b>	<b>87,344.1</b>	<b>20,706.4</b>
1	Аймгийн ИТХ	491.9	2,098.9	2,009.0	89.8
2	Сумын ИТХ	1,163.1	2,213.2	1,990.7	222.5
3	Аймгийн ЗДТГ	9,862.5	6,480.1	4,585.2	1,894.9
4	Сумын ЗДТГ	7,264.4	13,629.3	12,742.4	886.9
5	Хот тохижуулах газар	828.6	1,643.4	1,569.9	73.5
6	Захирагчийн ажлын алба	-	3,961.5	3,533.2	428.3
7	ОНӨГазар	182.0	332.2	301.3	31.0
8	Худалдан авах ажиллагаа	-	11.2	11.2	0.0
9	БОГазар	1,203.0	1,879.5	1,786.7	92.7
10	СХАА	193.4	361.7	312.4	49.3
11	НХҮХэлтэс	146.4	146.4	94.6	51.8
12	Засаг дарга-Урсгал зардал	1,339.2	8,002.4	6,663.6	1,338.8
13	Аймгийн ОНХОруулалт	-	50,942.5	36,878.3	14,064.2
14	НҮГ	-	1,084.3	1,067.2	17.1
15	ОНБ-уудын үйлчилгээ ашиглалт	9,437.9	9,469.6	8,649.6	820.0
16	Гадаад зээл тусламжийн эргэн төлөлт	(1,200.5)	-	-	-
17	Сумдын ОНХСанд олгох санхүүжилт	-	1,720.6	1,111.8	608.7
18	Замын Үүд сумын орон нутгийн хөрөнгө оруулалт	-	3,619.6	3,590.9	28.8
19	Замын Үүд сумын ойн анги	-	454.1	446.1	8.0
	<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>38,943.3</b>	<b>12,007.9</b>	<b>6,817.1</b>	<b>5,190.9</b>
	<b>Улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг</b>	<b>16,015.4</b>	<b>16,015.4</b>	<b>10,473.1</b>	<b>5,542.3</b>
	<b>Орон нутагт үлдэх</b>	<b>22,927.9</b>	<b>-</b>	<b>351.4</b>	<b>-</b>

Аймгийн орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг авч үзэхэд татварын болон татварын бус орлого 93,760.0 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 401.2 сая төгрөг, нийт 94,161.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, урсгал зардалд

46,874.9 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтын зардалд 40,469.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, улсын төсөвт 10,473.1 сая төгрөгийг орлогыг төвлөрүүлж, орон нутгийн орлогын үлдэгдэл 351.4 сая төгрөг байна.

**Аймгийн төсвийн 2023 оны төсвийн нийт гүйцэтгэл**

Хүснэгт №22

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2023 он			
		Тодотгол/ Зохицуулалт	Гүйцэтгэл	Зөрүү	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>86,074.4</b>	<b>163,640.6</b>	<b>133,119.2</b>	<b>30,521.5</b>	<b>81.3</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>53,435.9</b>	<b>109,078.4</b>	<b>92,649.7</b>	<b>16,428.8</b>	<b>84.9</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	10,678.2	16,600.0	15,687.5	912.5	94.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,469.6	2,151.4	1,942.3	209.1	90.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,480.8	10,334.8	9,439.1	895.7	91.3
Хангамж, бараа материалын зардал	1,240.7	1,807.8	1,652.4	155.3	91.4
Нормативт зардал	171.4	223.7	220.4	3.4	98.5
Эд хогшил, урсгал засварын зардал	1,358.5	2,044.7	1,882.1	162.6	92.0
Томилолт, зочны зардал	199.9	302.5	256.6	45.9	84.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,451.2	13,867.9	11,957.0	1,910.9	86.2
Бараа үйлчилгээний бусад зардал	1,199.2	3,560.6	2,744.0	816.6	77.1
Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	946.3	1,735.7	300.0	1,435.7	17.3
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	50.0	300.0	294.0	6.0	98.0
Урсгал шилжүүлэг	21,190.1	56,149.3	46,274.2	9,875.1	82.4
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>32,638.5</b>	<b>54,562.2</b>	<b>40,469.5</b>	<b>14,092.7</b>	<b>74.2</b>
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>91,858.3</b>	<b>163,640.6</b>	<b>125,519.0</b>	<b>38,121.6</b>	<b>76.7</b>
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	17,322.3	26,870.3	25,571.4	1,298.9	95.2
Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,625.4	119,755.5	97,416.1	22,339.4	81.3
Үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,910.6	2,145.7	2,531.5	(385.9)	118.0
Урьд оны үлдэгдлээс санхүүжих		14,869.2	-	14,869.2	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>6,462.4</b>		<b>12,246.4</b>		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>12,246.4</b>		<b>4,646.2</b>		

Аймгийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангаар зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нийт 125,519.0 сая төгрөг, үүнээс 97,416.1 сая төгрөг нь татварын болон татварын бус орлого, 25,571.4 сая төгрөг нь ОНХНС-аас олгосон санхүүжилт, 2,531.5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос тус тус бүрдүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 133,119.2 сая төгрөг, үүнээс ТЕЗ-ын харьяа төсөвт байгууллагуудын урсгал үйл ажиллагааны зардалд 37,113.5 сая төгрөг, тусгай сангуудын үйл ажиллагааны зардалд 36,413.7 сая төгрөг, ОНӨ-т байгууламжийн үйлчилгээ ашиглалтын зардалд 8,649.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 40,469.5 сая төгрөгийг тус тус зарцуулан, улсын төсөвт 10,473.1 сая төгрөгийг татан төвлөрүүлж, тусгай сангуудын мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 7,600.2 сая төгрөгийг зарцуулан, эцсийн үлдэгдэл 4,646.2 сая төгрөгөөр тайлагнасан байна.

**Аймгийн ТЕЗ-ийн анхааралд толилуулах нь:**

Аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд тусгасан 125,519.0 сая төгрөгийн орлого, 133,119.2 сая төгрөгийн зарлага, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 12,246.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,646.2 сая төгрөгийг аудитаар баталгаажууллаа.

## ДҮГНЭЛТ

Дорноговь аймгийн ТӨЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- МУ-ын 2023 оны Төсвийн тухай хуулиар аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг 56,790.6 сая төгрөгөөр баталж, нэмэлт өөрчлөлтөөр 13,064.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 69,855.3 сая төгрөгөөр тодотгож баталсныг аймаг, сумдын ИТХ-аас 50,203.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 120,058.4 сая төгрөгөөр баталсан байна.
- Сангийн яамнаас 2023 оны төсвийн орон нутгийн суурь зарлагыг 28,239.4 сая төгрөгөөр 2023 оны төсвийн тодотголоор суурь зарлагыг 31,670.6 сая төгрөгөөр баталсныг аймаг, сумдын ИТХ-аас 76,379.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 108,050.5 сая төгрөг болгож баталсан байна.
- Орон нутгийн 2023 оны орон нутгийн орлогын гүйцэтгэл 94,161.2 сая төгрөг буюу хэрэгжилт 78.4 хувь, зардлын гүйцэтгэл 87,344.1 сая төгрөг, төлөвлөгөөний хэрэгжилт 80.8 хувьтай байна. Энэ нь Сангийн яам 2023 оны 06-р сарын 16-ны өдөр суурь орлогыг 13,064.7 сая төгрөгөөр, төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 7,231.7 сая төгрөгөөр нэмэгдүүлснээс тус тус шалтгаалжээ.
- ААНОАТ-ын орлогоос аймагт 21,910.0 сая төгрөг төвлөрөхөөс 24,983.1 сая төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөөг 14.0 хувиар давуулан биелүүлсэн байна.
- Газрын дуудлага худалдааны орлого 37,516.0 сая төгрөг төвлөрөхөөс 6,464.3 сая төгрөг төвлөрүүлэн 31,051.7 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь шинээр газар олгох үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотой газрын биржийн цахим системд хаалт хийж 3 сарын хугацаанд газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах боломжгүй болсонтой холбоотой байна.
- Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэхээр орлого 5,542.3 сая төгрөгөөр тасарсан байна. Тайлант онд орон нутгийн төсвөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 4 төсөл арга хэмжээний санхүүжилтэд 3,755.1 сая төгрөгийг олгосон нь улсын төсөвт аймгаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн байна. Мөн улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр 2 дахин нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.
- Сумдын орон нутгийн орлогоос аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,878.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.
- Аймгийн төсвөөс 5 суманд 1,563.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.


**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

АУДИТЫН МЕНЕЖЕР  У.ОЮУНТҮЛХҮҮР


**АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР




О.НАРАНГАРАВ

АУДИТОР



Д.ДЭМБЭРЭЛСҮРЭН

АУДИТОР



М.ДҮҮРЭНЖАРГАЛ

АУДИТОР

Н.МӨНХНАСАН

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД  
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.